



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны II улирал



Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга 2024 оны 2 дугаар улирал, Эдийн засаг, хөгжлийн яам” хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу. Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны II улирал

АГУУЛГА

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ	5
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ	6
1. БОДИТ СЕКТОР	7
1.1. Нийт нийлүүлэлт	9
1.2. Нийт эрэлт	12
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж	14
1.4. Эдийн засгийн мөчлөг	18
2. ТӨСВИЙН СЕКТОР	19
2.1. Төсвийн бодлого	21
2.2. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	23
3. МӨНГӨНИЙ СЕКТОР	28
3.1. Инфляц ба мөнгөний бодлого	30
3.2. Санхүүгийн салбар	35
4. ГАДААД СЕКТОР	39
4.1. Гадаад худалдаа	41
4.2. Төлбөрийн тэнцэл	45
4.3. Гадаад өр	47
5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ	49
5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	51
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	53
5.3. Олон улсад 2024 онд зарлагдсан индексүүд	56
Макро эдийн засгийн тойм-2024 оны 8 дугаар сар	60
Хавсралт	64

ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт	9
Зураг 1.2. Том малын зүй бус хорогдол	11
Зураг 1.3. Том малын зүй бус хорогдлын 2024 оны төсөөлөл	11
Зураг 1.4. Өсөлтийн бүтэц	13
Зураг 1.5. Хөдөлмөрийн зах зээл	14
Зураг 1.6. Дундаж цалин	15
Зураг 1.7. Аж ахуйн нэгж	15
Зураг 1.8. ААН-ийн бодит борлуулалт	16
Зураг 1.9. Ажиллах хүчний оролцооны түвшин	17
Зураг 1.10. Үйлдвэрлэлийн зөрүү	18
Зураг 2.1. Төсвийн орлого	21
Зураг 2.2. Төсвийн зарлага	21
Зураг 2.3. Төсвийн нийт тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч	22
Зураг 2.4. Төсвийн төлөв	22
Зураг 2.5. Төсвийн импульс	22
Зураг 2.6. Засгийн газрын өр	23
Зураг 2.7. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	24
Зураг 2.8. Урсгал зардал	26
Зураг 2.9. Төсвийн тэнцэл	26
Зураг 2.10. Татварын орлого	27

Зураг 3.1.	Инфляцын бүрэлдэхүүн	30
Зураг 3.2.	Тэйлорын хүү, мөнгөний зорилтот өсөлт	32
Зураг 3.3.	Голлох бүтээгдэхүүний үнэ	33
Зураг 3.4.	Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд	35
Зураг 3.5.	Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд	36
Зураг 3.6.	Нийт хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн түвшин	37
Зураг 3.7.	Арилжааны банкнуудын ашигт ажиллагаа ба зохистой харьцааны үзүүлэлт	38
Зураг 3.8.	Хөрөнгийн зах зээл	38
Зураг 4.1.	Гадаад худалдааны үзүүлэлт	41
Зураг 4.2.	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа	42
Зураг 4.3.	Импорт	43
Зураг 4.4.	Төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш	45
Зураг 4.5.	Урсгал дансны тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	46
Зураг 4.6.	Гадаад өр	47
Зураг 4.7.	Гадаад өрийн тогтвортой байдал	48
Зураг 5.1.	PMI индекс	51
Зураг 5.2.	Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ	54
Зураг 5.3.	ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хэмжээ, сүүлийн 3 жилийн дундаж, Монгол Улс	58
Зураг 5.4.	ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хэмжээ, сүүлийн 3 жилийн дундаж, улсууд, децилээр	58
Хүснэгт 1.	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор	16
Хүснэгт 2.	Төсвийн тусгай шаардлага, түүний өөрчлөлт	25
Хүснэгт 3.	Засгийн газрын өр	26
Хүснэгт 4.	Эрчим хүчний өртөг ба тариф, бүс нутгаар	34
Хүснэгт 5.	Нийт зардалд эзлэх цахилгаан, дулааны хувь, салбараар	34
Хүснэгт 6.	Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ	56
Хүснэгт 7.	Бертельсманн шилжилтийн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ	57
Хүснэгт 8.	Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ	57
Хүснэгт 9.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт	59
Хүснэгт 10.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	65
Хүснэгт 11.	Бодит секторын үзүүлэлтүүд	66
Хүснэгт 12.	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд	67
Хүснэгт 13.	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувиар)	68
Хүснэгт 14.	Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд	69
Хүснэгт 15.	Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувиар)	70
Хүснэгт 16.	Мөнгөний үзүүлэлтүүд	71
Шигтгээ 1.	Хөдөө аж ахуйн салбар ба том малын зүй бус хорогдол	11
Шигтгээ 2.	Ажиллах хүчний оролцооны түвшин	17
Шигтгээ 3.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлтийн талаар	25
Шигтгээ 4.	Төсвийн орлогод үзүүлэх цахимжуулалтын үр нөлөө	27
Шигтгээ 5.	Эрчим хүчний салбарын шинэчлэл	34
Шигтгээ 6.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүн	59

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОАТ	Онцгой албан татвар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЭС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Уул уурхайн салбар болон дотоод эдийн засгийн идэвхжилийн нөлөө өсөлтийг дэмжиж, Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний хагас жилд 5.6 хувиар өслөө. Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үүнийг дагаад тээврийн салбарын өсөлт хадгалагдлаа. Зам, гүүрний бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын салбар тэлж, боловсруулах салбарын үйлдвэрлэл тогтвортой байсан нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлжээ. Мөн худалдаа, үйлчилгээний салбаруудын өсөлт хадгалагдлаа. Харин том малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрсэн нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэв.

Өрхийн хэрэглээ болон эргэлтийн хөрөнгийн хуримтлал эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас дэмжив. Төрийн албан хаагчдын цалин нэмэгдэж, өрхийн цалингийн орлогын өсөлт болон хэрэглээний зээлийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн хэрэглээ өсөж, нийт эдийн засгийг эрэлт талаас голлон дэмжлээ. Мөн эдийн засгийн эрэлтэд бизнесийн зээл болон импортын сувгаар дамжин материаллаг эргэлтийн хөрөнгийн өсөлт нөлөөллөө.

Төсвийн нийт тэнцэл 2024 оны 2 дугаар улиралд 57.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. БНХАУ-ын нүүрсний үйлдвэрлэл буурснаар эрэлт нь өсөж, нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны эхний хагас жилд 40.6 сая тоннд хүрч, уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 6.4 их наяд төгрөг хүрснээр нийт тэнцэл 57.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан хэдий ч үүнээс улирлын нөлөөг арилгавал 40.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон нутагт ажиллах, амьдрах таатай орчныг бүрдүүлэхтэй холбоотойгоор цалингийн зардлыг нэмэгдүүлсэн нь эдийн засагт эрэлт талаас эерэг нөлөө үзүүлсэн байна. Засгийн газрын өрийн төлөв тогтвортой хадгалагдаж байгаа хэдий ч нийслэлийн гадаад, дотоод зах зээлд гаргах үнэт цаастай холбоотойгоор дунд хугацаанд Засгийн газрын өрийн хэмжээ өсөх хүлээлттэй байна.

Инфляц төв банкны зорилтот интервалын доод түвшинд буюу 5.1 хувьд хүрч төсөөллөөс бага байж, мөнгөний бодлогын хүү дахин буурснаар банкнуудын шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдлээ. Инфляцын түвшин буурч бодит хүү нэмэгдсэн, төгрөгийн ханш тогтвортой байсан нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, нийт хадгаламжийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв. Мөн валютын хадгаламж, харилцах буурч, төгрөгийн харилцах, хадгаламж нэмэгдлээ. Арилжааны банкнуудын зээлийн эх үүсвэр нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжид шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 5.9 хувь буюу сүүлийн 8 жилийн хамгийн бага түвшинд хүрч буурсан байна.

Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн нь экспортын өсөлтийг дэмжлээ. Оны эхний хагас жилд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэнээр нийт экспортын орлого өмнөх оны мөн үеэс 4 хувиар өслөө. Харин дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, өрхийн орлого, арилжааны банкнуудын зээл олголт нэмэгдэж, иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирсан нь импортын өсөлтийг өдөөж, гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдэхэд голлон нөлөөлөө. Импорт өсөж, төв банкнаас своп хэлцлийн өр төлбөрийн хэсгийг эргэн төлсөнтэй холбоотойгоор төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч, өмнөх улиралтай харьцуулахад гадаад валютын нөөц буурч, төгрөгийн ханш суларлаа.

Цаашид зээлжих зэрэглэлийг сайжруулах, эдийн засгийн хямралаас сэргийлэхэд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь чухал байна. Макро эдийн засгийн тогтвортой байдлын чухал хэсэг болох төсвийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой хуульд заасан тусгай шаардлагуудыг өөрчилсөн нь эдийн засагт дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад хамрагдах төсвийн тэнцэл болох нэгдсэн төсвийн суурь тэнцлийг тооцоход үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй байх зохицуулалтыг тусгасан байгаа нь цаашид төсвийн хөрөнгийн зардал огцом нэмэгдэж, төсвийн сахилга бат алдагдах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо буурч, төрийн оролцоо нэмэгдэх, Засгийн газар болон орон нутгийн төсвийн захирагч нар хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх зорилгоор хэт их үнэт цаас гаргаж санхүүгийн зах зээлийн тэнцвэр алдагдах, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг бий болгож байна. Түүнчлэн нэгдсэн төсвийн урсгал зардлын дээд хэмжээг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь хүртэл нэмэгдүүлж болохоор хуульд өөрчлөлт оруулсан нь цаашид төсвийн урсгал зардал хурдтай нэмэгдэх, уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл болон эдийн засгийн мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжих нөхцөлийг бүрдүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдалд алдагдаж, улсын зээлжих зэрэглэл буурах эрсдэл үүсэж байна.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.6 орчим хувь байхаар төсөөлж байна.¹ Оюутолгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь нь газрын гүнд оршдог ба эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэнэ. Мөн нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өсөж, уул уурхай болон тээврийн салбарын өсөлтөд эергээр нөлөөлнө. Харин малын хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын уналт нь эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн өсөлтийг хязгаарлахаар байна. Цаашид цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, төсвийн тэлэлтийн нөлөөгөөр дотоод эдийн засгийн эрэлт өсөхөөр байна. Мөн 2024 оны эхний хагас жилд үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт сайжирсан, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн тоо болон зээл олголт нэмэгдсэн нь оны хоёрдугаарт хагаст үйлчилгээний салбарын эрэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны жилийн эцэст 28.5 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн нөлөөгөөр 2024 онд зэсийн баяжмалын экспорт 1,560 мянган тоннд хүрч нэмэгдэхээр байна. Түүнчлэн, хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн

үр дүнд нүүрсний экспорт 78 сая тоннд, төмрийн хүдрийн экспорт 8,400 мянган тоннд, газрын тосны экспорт 4,210 мянган баррельд тус тус хүрч, нийт экспортын дүн 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт, бизнесийн зээл нэмэгдэж буй нөлөөгөөр уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өсөхөөр байна. Мөн өрхийн орлого өсөж, хэрэглээний зээл олголт нэмэгдсэнээр хүнс, хэрэглээний бараа, шатахууны импорт өсөх төлөвтэй байна. Ингэснээр нийт импорт 2024 оны эцэст 11.8 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Инфляц 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшин болох 6 ± 2 хувийн дээд интервал орчимд байхаар төсөөлж байна. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн нь махны нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцыг нэмэгдүүлж болзошгүй байгаа бол 2025 онд нэгдсэн төсвийн нийт/урсгал зарлага тэлж байгаа нь эрэлт талаас инфляцыг өдөөх эрсдэлтэй байна. Түүнчлэн Тяньжин боомт дээрх чингэлгийн бөөгнөрөл удаан үргэлжилж, тээврийн үнэ өсөх, геополитикийн тогтворгүй байдлын улмаас улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг импортын голлох бараа бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ нэмэгдэх зэрэг инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хэвээр байна.

¹ Эдийн засгийн өсөлтийн 2023 оны гүйцэтгэл 2024 оны 8 дугаар сард эцэслэгдэн зарлагдаж, 7.4 хувьд хүрсэнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлтийн 2024 оны өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс бага зэрэг буурууллаа.

БҮЛЭГ 1

БОДИТ СЕКТОР

- 1.1 НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ
- 1.2 НИЙТ ЭРЭЛТ
- 1.3 ХӨДӨЛМӨР БА АЖ АХУЙН НЭГЖ
- 1.4 ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

1. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Дотоод эдийн засгийн идэвхжил 2024 оны эхний хагас жилд сайжирч, эдийн засаг 5.6 хувиар өслөө. Өвөлжилт, хаваржилтын хүндрэл хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бууруулснаар эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас удааширлаа. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортын өсөлтийг дагаад тээврийн салбар тэлсэн бол томоохон инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтууд үргэлжилж, барилгын салбар өндөр өсөлттэй байна. Мөн төрөөс машин тоног, төхөөрөмжийн импортын татварыг тэглэх замаар боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих бодлогын үр нөлөөгөөр тус салбар сүүлийн 5 улирал дараалан тэлж, өсөлт эрчимжиж байна. Төрийн албан хаагчдын цалингийн өсөлтийг дагаад хувийн секторт цалин өсөж, хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлж байгаа ч цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн амьжиргаа төдийлөн сайжрахгүй байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжилснээр хөдөө орон нутагт өрхийн амьжиргаа хүнд хэвээр байна. Үйлдвэрлэлийн хүчин чадал өргөжин, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнээр эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн потенциал нэмэгдэж байна.


НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ

1. Эдийн засгийн өсөлт хөдөө аж ахуйн салбарын уналтаас үүдэн өмнөх улирлаас удааширлаа. Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний хагас жилд 37 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 14.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өслөө. Өвөлжилт, хаваржилтын хүндрэл хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бууруулснаар эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас удааширлаа. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлж байна (Зураг 1.1). Цаашид хөдөө аж ахуйн салбарын уналт эдийн засгийн өсөлтийн төлөвийг бууруулах хэдий ч уул уурхайн олборлолт болон өрхийн хэрэглээний өсөлтийг даган худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, өсөлт 2024 оны эцэст 5.6 орчим хувьд хадгалагдахаар байна.

2. Нүүрс, төмрийн хүдрийн олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэлийн нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл өслөө. Уул уурхайн салбар 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн гуравны нэг орчмыг бүрдүүллээ (Зураг 1.1). Үүнд, нүүрс олборлолт 47.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 36 хувиар, төмрийн хүдрийн олборлолт 4.6 сая тоннд хүрч 47 хувиар тус тус өсөж, олборлолт тогтвортой нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Мөн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 2024 оны нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буураад байсан бол эхний хагас жилд Оюутолгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл нэмэгдсэний нөлөөгөөр 4.3 хувиар өссөн байна. Харин газрын тос, алт олборлолт харгалзан 13 болон 18 хувиар тус тус буурсан байна. Уул уурхайн салбарын гүйцэтгэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар төсөөллийн орчимд байна.


Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт

1. Эдийн засгийн өсөлт дахь салбаруудын оролцоо
(нэгж хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.

2. Салбаруудын бодит өсөлт (өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Салбаруудын бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийг харуулав.

3. Том малын зүй бус хоргодол ба төл бойжилт
(мянган толгой мал)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Төл бойжилт, том малын зүй бус хоргодлын жил бүрийн эхний хагас жилийн тоо хэмжээг харуулав.

3. Уул уурхайн бус салбар 2024 оны эхний хагас жилд 4.2 хувиар тэлж, өсөлтийн гуравны хоёрыг бүрдүүллээ.

Тухайлбал тээвэр, худалдаа, боловсруулах, барилга, үйлчилгээ зэрэг салбаруудын үйлдвэрлэл тэлсэн нь өсөлтийг дэмжиж байгаа бол хөдөө аж ахуйн салбарын уналт сөргөөр нөлөөлж байна.

4. Нүүрсний экспорт тээврийн салбарыг дэмжсээр байна. Ачаа тээвэр 2024 оны эхний хагас жилд 55.6 сая тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 23 хувиар нэмэгдсэнээр тээврийн салбарын үйлдвэрлэл 25 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 1.0 нэгж хувиар дэмжлээ (Зураг 1.1). Үүнд, чулуун нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 27 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлэв. Мөн төмөр замын тээврийн орох урсгал (бараа бүтээгдэхүүний импорт) болон дамжин өнгөрөх тээвэр харгалзан өмнөх оны мөн үеэс 13.2 болон 8.9 хувиар тус тус нэмэгдэж тээврийн салбарын өсөлтөд эерэг нөлөө үзүүлж, тээврийн салбарын өсөлт төсөөлөлтэй нийцтэй байна.

5. Бүх төрлийн ундааны үйлдвэрлэл нэмэгдэж боловсруулах салбар өсөлтөө хадгалсаар байна. Боловсруулах салбар 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжлээ. Үүнд, тус салбарын 25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлөв. Тухайлбал, амтат ус, ундааны үйлдвэрлэл 15 хувиар, архины үйлдвэрлэл 59 хувиар, жүүсний үйлдвэрлэл 55 хувиар тус тус нэмэгдлээ. Харин боловсруулах салбарын 10-15 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах үйлдвэрлэл мал хорогдлын нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 25 хувиар буураад байна.

6. Инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын салбарын өсөлт эрчимжив. Улаанбаатар хотын далан, суваг, шугам сүлжээний ажил, Дархан-Уул, Ховд,

Өмнөговь, Улаанбаатар хотын автозамын ажил болон Алтанширээтийн аж үйлдвэрийн парк руу чиглэсэн төмөр зам, Шивээхүрэн-Сэхээ боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын голлох нөлөөгөөр барилгын салбар өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.3 нэгж хувиар дэмжлээ. Барилгын салбарын гүйцэтгэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар төсөөллийн орчимд байна.

7. Үйлчилгээний салбар хүлээлтээс давж, эдийн засгийн өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна.

Салбарт хамгийн өндөр жин дардаг бөөний болон жижиглэн худалдаа 2024 оны эхний хагас жилд хүлээлтээс давж 6.8 хувиар өсөв. Худалдааны салбарын борлуулалтын орлогын 79 хувийг² бүрдүүлдэг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт өсөхөд моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги, шатахууны бөөний худалдаа нэмэгдсэн нь гол нөлөөлсөн бөгөөд өрхийн хүнсний бус хэрэглээ, хэрэглээний импортын өсөлт мөн нөлөөлжээ. Түүнчлэн мэдээлэл, холбооны салбар өндрөөр бууу 17.4 хувиар өсөж, үйлчилгээний бусад салбарууд 7.1 хувиар тэлэв. 2024 оны эхний хагас жилд үйлчилгээний салбаруудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, хөдөлмөр эрхлэлт, зээл олголт нэмэгдсэний нөлөөгөөр тус салбарын өсөлт оны сүүлийн хагаст тогтвортой хадгалагдахаар байна.

8. Том малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрч хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлалаа.

2024 оны эхний хагас жилийн байдлаар том малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмэгдэж, төл бойжилт 2.6 сая толгой малаар буурч 15.4 сая толгой болсноор хөдөө аж ахуйн салбар 26.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.9 нэгж хувиар хязгаарлалаа (Зураг 1.1). Хорогдсон малын тоо 2024 оны эхэнд тоологдсон нийт малын 12.5 хувьд хүрлээ.

² 2024 оны эхний хагас жилийн байдлаар худалдааны салбарын борлуулалтын орлогын 21 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 79 хувийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна. Эх сурвалж: ҮСХ

ШИГТГЭЭ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР БА ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ


НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хөдөө аж ахуйн салбар 2024 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.9 нэгж хувиар хязгаарлалаа. Хөдөө аж ахуйн салбар нь уул уурхайн салбарын дараа ордог буюу Монгол Улсын эдийн засгийн 10 хувийг бүрдүүлдэг салбар юм. Тус салбарын 90 орчим хувийг мал аж ахуй, 10 орчим хувийг газар тариалангийн салбар тус тус бүрдүүлж байна. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь цаг уурын өөрчлөлтөөс өндөр хамааралтай байдаг тул үйлдвэрлэлийн гарц өндөр хэлбэлзэлтэй байдаг. Өнгөрсөн 2023-2024 оны өвөл нийт нутгийн 90 гаруй хувьд цасан бүрхүүлтэй, өвлийн туршид огцом дулаарал болон хүйтрэл ажиглагдсаны улмаас 14 аймгийн 46 суманд мөсөн (төмөр) зуд, харин говийн аймгийн зарим сумдын нутгаар зундаа гантай байснаас харын зудын нөхцөл тус тус үүссэн. Өвөлжилтийн хүндрэлээс шалтгаалан 2023 оны жилийн эцэст өмнөх оноос 6.4 сая толгойгоор бага мал буюу 64.7 сая толгой мал тоологдсон бол 2024 оны эхний хагас жилд 8.1 сая толгой мал хорогдож, 2023 оны эцэст тоологдсон малын 12.5 хувьтай тэнцлээ. Хорогдсон том малын 63 хувийг нийт малын 30 хувийг бүрдүүлдэг Архангай, Төв, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгууд бүрдүүлсэн байна.

Зураг 1.2 Том малын зүй бус хорогдол

1. Том малын зүй бус хорогдол


(өссөн дүнгээр, улирлаар, сая толгой)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Том малын зүй бус хорогдол,

(аймгаар, сая толгой)



Powered by Bing
© GeoNames, TomTom, Wikipedia


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨСӨӨЛӨЛ

2024 оны жилийн эцэст том малын зүй бус хорогдол 10.1 сая толгойд хүрч, нийт малын тоо толгой 2015-2016 оны түвшинтэй ижил түвшинд хүрэх төлөвтэй байна. Хорогдлын хэмжээг байршлаар харвал Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Увс аймгуудад малын хорогдол өндөр байх төлөвтэй байна.

Зураг 1.3 Том малын зүй бус хорогдлын 2024 оны төсөөлөл


1. Том малын зүй бус хорогдол, өссөн дүнгээр, жилээр (сая толгой)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Үндэсний статистикийн хороо

2. 2024 оны том малын зүй бус хорогдлын төсөөлөл

(аймгаар, сая толгой)



Powered by Bing
© GeoNames, TomTom, Wikipedia

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Том малын зүй бус хорогдолд үзүүлэх өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн нөхцөл байдлын төлөөлөх хувьсагчаар 2008 – 2023 оны нэгдүгээр сараас гуравдугаар сарын дундаж хур тунадасны нийлбэр хэмжээг сонгон авч сүргийн эргэлтийн тооцоолоор 2024 оны том малын зүй бус хорогдлын хэмжээг төсөөлөв. 2023-2024 оны мал өвөлжилтийн цаг агаарын нөхцөлийн тойм <http://w.tsag-agaar.gov.mn>

9. Эдийн засгийн дотоод идэвхжил хүлээлтийг давж, өсөлтийг тэтгэж байна. Эрэлт талаас тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны эхний хагас жилд 5.7 хувиар өсөхөд өрхийн хэрэглээ 12.1 нэгж хувийн, төрийн хэрэглээ 9.3 нэгж хувийн, эргэлтийн хөрөнгийн хуримтлал 6.0 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулсан бол цэвэр экспорт буюу бараа, үйлчилгээний гадаад худалдааны тэнцэл 21.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 46.9 хувиар, өрхийн хэрэглээ³ 16.9 хувиар тус тус тэлж, дотоод эрэлт хүлээлтээс өндрөөр буюу өсөлтөд 27.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Эдийн засгийн идэвхжил, хэрэглээний өсөлтийг дагаад барааны импортын өсөлт 29.4 хувьд хүрсэн байна. Энэ оны сүүлийн хагас жилд амралт, аялал жуулчлалын идэвхэжсэнээр дотоод эрэлтийн сайн төлөв хадгалагдан эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

10. Өрхийн бодит орлого 17.3 хувиар сайжирсан ч өсөлт оны сүүлийн хагас жилд суурийн нөлөөгөөр саарахаар байна. Улсын хэмжээнд өрхийн дундаж нэрлэсэн орлого өмнөх оны мөн үеэс 486 мянган төгрөгөөр нэмэгдэн, 2.5 сая төгрөг болоход цалингийн орлого дунджаар 371 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 70 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 1-ээс төрийн албан хаагчдын цалинг 10-40 хувиар нэмэгдүүлсэн. Түүнчлэн цалин хөлстэй ажил эрхлэгчдийн тоо эхний хагас жилийн байдлаар 1,347 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.6 хувь болж, 2.3 нэгж хувиар тус тус сайжирсан нь өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлж байна. Өрхийн орлогын өсөлт оны сүүлийн хагас жилд өмнөх оны суурийн нөлөөгөөр саарах төлөвтэй байна.

11. Иргэдийн зээл олголт нэмэгдэн өрхийн хэрэглээ өсөж байна. Цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээлийн олголт нэмэгдэж, иргэдийн зээлийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 40.8 хувиар өсөн өрхийн хэрэглээг эрчимжүүлж байна. Өрхийн хүнсний хэрэглээ өмнөх оны түвшинд байгаа бол хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ 28.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнд хамгийн өндөр дүнгээр тээврийн зардал 43.4 хувиар өссөн бол хувцас, гутал, удаан эдэлгээт эд хогшлынх 45.1 хувиар, орон сууц ашиглалттай холбоотой зардал 17.9 хувиар тус тус өссөн байна.

Төв банк 2024 оны 6 болон 7 дугаар сарын ээлжит хуралдаанаараа хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг сулруулах шийдвэр⁴ гаргасан. Мөн иргэдийн хадгаламж оны эхний хагас жилд 22.3 хувийн өсөлттэй байгаа нь цаашид өрхийн хэрэглээг нэмэгдүүлэх магадлалтай юм.

12. Улаанбаатарт өрхийн дундаж орлого 21.3 хувиар өссөн бол хөдөөд 1.4 хувиар л нэмэгджээ. Нийт өрхийн 47.3 хувь нь нийслэлд, 21.7 хувь нь бусад хот, сууринд, үлдсэн 31 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийслэлийн өрхийн дундаж орлого 2.9 сая төгрөг байгаа бол хөдөөгийн өрхийнх 2.0 сая төгрөг байна. Хот суурины өрхийн орлогын 60 орчим хувь нь цалингаас бүрдэж байгаа бол малчин өрхүүд орлогынхоо 50 орчим хувийг мал аж ахуйн үйлдвэрлэлээс олж байна. Оны эхний хагас жилд мал аж ахуйн гарц буурснаар малчдын мал аж ахуйн орлого 10.9 хувиар муудаж, тэдний орлогын өсөлт улсын дундаж өсөлтөөс удаан байна.

³ Өрхийн хэрэглээнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг нэмж оруулав.

⁴ Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 6 дугаар сарын 25, 7 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хурлаар банкнаас шинээр олгох амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага дүнтэй кредит картын зээлд өр, орлогын харьцаа

(ӨОХ)-ны хязгаарлалт мөрдүүлэхгүй байх; Тодорхой нөхцөлүүдийг хангасан дээд боловсролын сургалтын төлбөрийн зээлд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтыг мөрдүүлэхгүй байх шийдвэрийг тус тус гаргасан.

13. Цалингийн орлого багатай иргэдийн амьжиргаа сайнгүй хэвээр байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр нийт өрхийн 36.5 хувь нь 1.6 сая төгрөгөөс бага орлоготой байгаа ба тэдний дундаж орлого ойролцоогоор нэг сая төгрөг байна. Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн дундаж орлого 3.2 сая төгрөг байгаа юм. Түүнчлэн 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн цалингийн орлого тэдний нийт орлогын 62.1 хувийг бүрдүүлж байхад бага орлоготой өрхийн орлогод цалингийн орлого нь ердөө 23.5 хувийг эзэлж байна. Үүнээс гадна бага орлоготой өрхийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 34.7-105.6 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн орлого муутай эдгээр өрхүүдэд цалингийн өсөлт төдийлөн нөлөөлөхгүй байгааг харуулж байна.

14. Материаллаг эргэлтийн хөрөнгийн хуримтлал өсөө. Хөрөнгийн хуримтлал нь үндсэн хөрөнгийн хуримтлал болон материаллаг эргэлтийн хөрөнгийн хуримтлалаас бүрддэг. Хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 17.6 хувь өсөхөд материаллаг эргэлтийн хөрөнгө оны эхний хагас жилд 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн нь голчлон нөлөөллөө. Хэдийгээр эдийн засагт нэмэгдсэн машин тоног төхөөрөмжийн өсөлт өмнөх оны мөн үеийн түвшнээс 30.6 хувиар, орон сууцны бус барилга байгууламж 29.4 хувиар өндөр байгаа ч том малын тоо толгой олноор хорогдсоны улмаас биологийн өсөж үрждэг хөрөнгийн хуримтлал буурснаар нийт үндсэн хөрөнгийн хуримтлал 0.7 хувийн өсөлттэй байна. Аж ахуйн нэгж байгууллагад шинээр олгосон зээл оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 70.7 хувиар, төсвийн хөрөнгө оруулалт 3.7 дахин өсөж эдийн засаг дах хөрөнгийн нийлүүлэлт өсөлттэй байна.

15. Бараа, үйлчилгээний импорт 20.6 хувиар өссөнөөр цэвэр экспорт буурч, нийт эрэлтэд сөрөг нөлөө үзүүлэв. Төгрөгийн ханш чангарч, гадаад зах зээл дэх үнэ бууран импортын бараа бүтээгдэхүүний үнэ хямдарснаас гадна дотоод эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр хэрэглээ болон хөрөнгө оруулалтын бараа, бүтээгдэхүүний импорт өсөв. Нөгөөтээгүүр нүүрсний тоо хэмжээ өссөн ч үнэ 18.0 хувиар буурснаар барааны экспорт бага зэрэг агшин, цэвэр экспорт 81.9 хувиар буурав. Эдийн засаг идэвхжилтэй зэрэгцэн Үүнд барааны импорт өмнөх оны мөн үеэс 29.4 хувиар өссөн бол уул уурхайн экспорт эрчимжиж байна.


Зураг 1.4. Өсөлтийн бүтэц

1. Эдийн засгийн өсөлт
(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Хуримтлагдсан жилийн өсөлтийг харуулав

2. Өрхийн орлого
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Хуримтлагдсан жилийн өсөлтийг харуулав

3. Үндсэн хөрөнгийн хуримтлал
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Хуримтлагдсан жилийн өсөлтийг харуулав

ХӨДӨЛМӨР БА АЖ АХУЙН НЭГЖ

16. Хөдөлмөрийн зах зээл сэргэж цар тахлын өмнөх түвшинг давлаа. 2024 оны 2 дугаар улиралд ажилчид өмнөх оны мөн үеэс 68 мянгаар, цар тахлын өмнөх үеэс 72⁵ мянгаар нэмэгдэж 1 сая 347 мянгад хүрлээ. Ингэснээр ажиллагчдын тоог Ковид-19 цар тахлаас хойших өсөлтийн трендээ хадгалж 1 сая 200 мянгад хүрэхээр таамагласнаас 16 хувиар давав. Ажилчдын тоог улирлын нөлөөллийг⁶ нь арилгаж тооцвол өмнөх оны мөн үеэс 46 мянгаар нэмэгдсэн байна. Ажилчдын тооны өсөлтөд худалдаа, үйлчилгээний салбарын ажилчид харгалзан 47 мянга, 41 мянган хүнээр өссөн нь голчлон нөлөөлжээ. Харин хөдөө аж ахуйн салбарын уналтын нөлөөгөөр тус салбарын ажилчид 42 мянгаар буурсан нь ажилчдын тооны өсөлтийн хурдыг саарууллаа. Байршлаар харвал хотод нийт ажилчдын 617.4 мянга бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 71.2 мянгаар өссөн үзүүлэлттэй байгаа бол хөдөөд 54 хувь буюу 729.7 мянган хүн ажилтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.1 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

17. Эмэгтэйчүүдийн ажилгүйдэл нэмэгдэв. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 6 мянган хүнээр өсөж 82.3 мянгад хүрэв. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсөж 5.8 хувьд хүрлээ. Хүйсээр харвал нийт ажилгүй иргэдийн 58 хувь нь эрэгтэй, 42 хувь нь эмэгтэй байна. Эрэгтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1 мянгаар өсөж 47.6 мянгад хүрсэн бол эмэгтэй ажилгүй иргэдийн тоо 5.1 мянгаар өсөж 35 мянгад хүрчээ.

⁵ Ажиллах хүчний түүвэр судалгааны жингийн тооцоололд өөрчлөлт орсон тул шинэчлэгдсэн тоог ашиглав.

⁶ Улирлын нөлөө арилгах гэдэг нь хугацааны цувааны өгөгдөл дэх улирлын тогтмол хэв шинжүүдийг арилгах статистикийн арга юм. Эдгээр хэв шинжүүд нь цаг агаарын өөрчлөлт, баяр ёслол, сургууль, цэцэрлэгийн хуваарь, хөдөө аж ахуйн цикл гэх мэт янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж болдог. Энэхүү тогтмол хэлбэлзлийг арилгаснаар өгөгдөл дэх бодит чиг хандлага, мөчлөгийн хөдөлгөөнүүдийг ажиглахад илүү хялбар болгодог бөгөөд өөр өөр хугацааны мэдээллийг хооронд нь харьцуулах боломжтой болно.

Зураг 1.5. Хөдөлмөрийн зах зээл

1. Ажилчдын тоо, ажиллах хүчний оролцооны түвшин (мянган хүн; зүүн тэнхлэг, хувь: баруун тэнхлэг)



2. Ажилчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



3. Хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)



18. Иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх хандлага нэмэгдэж байна. Ажилчид болон ажилгүй иргэд өссөнөөр эдгээрийн нийлбэрээр хэмжигддэг ажиллах хүчний үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 74 мянгаар өсөж 1 сая 429 мянгад хүрлээ. Ажиллах хүч ийнхүү өссөнөөр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар нэмэгдэж 62.2 хувьд хүрэв. Улирлын нөлөөг арилгаж тооцвол 60.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин хөдөлмөрийн насны хүн амын 38 хувийг эзэлж буй ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо өмнөх оны мөн үеэс 49 мянгаар буурч 869 мянгад хүрсэн байна. Үүнээс дүгнэхэд ажиллах хүчнээс гадуурх хүн амын хөдөлмөрийн идэвх нэмэгдэж ажилчид болон ажилгүй иргэдийн эгнээнд шилжжээ. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын бууралтын шалтгааныг авч үзвэл, жирэмсэн, хүүхэд асарсан хүний тоо 19 мянгаар, өвчтөн, өндөр настан асарсан, ажил хайгаад олдохгүй байсан, ажиллах сонирхолгүй байсан иргэдийн тоо тус бүр 6 мянгаар буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Энэ нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

19. Хөдөө аж ахуйн бүтээмжийн түвшин буурсан нь хөдөлмөрийн бүтээмжийн түвшинд сөргөөр нөлөөллөө. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурч 5 сая 936 мянгад хүрлээ. Салбараар авч үзвэл аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 1 хувиар өсөж 3 сая 882 мянгад хүрсэн байна. Харин хөдөө аж ахуйн салбарын уналтын нөлөөгөөр нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмжийн түвшин 35 хувиар буурч 3 сая 902 мянгад хүрсэн байна. Түүнчлэн уул уурхай, үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмжийн түвшин харгалзан 2.5 хувь, 8 хувиар буурсан бөгөөд үүнд тус салбаруудад ажилчдын тоо өссөн нь нөлөөлжээ.

20. Цалин өсөж байгаа хэдий ч нийт ажилчдын талаас илүү хувь нь дундаж цалингаас бага цалин авч байна. 2024 оны 2 дугаар улиралд нэрлэсэн дундаж цалин өмнөх оны мөн үеэс 452.9 мянгаар өсөж 2.3 сая төгрөгт хүрэв. Мөн голч цалин⁷ өмнөх оны мөн үеэс 445.9 мянгаар өсөж 1.8 сая төгрөг болсон нь ажилчдын тал хувь нь 1.8 сая төгрөгөөс доош, тал хувь нь тус дүнгээс өндөр цалин авч байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд, хэдийгээр дундаж цалин 2 сая төгрөг давсан ч бодит байдал дээр нийт ажилчдын талаас илүү хувь нь дундаж цалингаас бага цалин авч байгааг илтгэж байна. Дундаж цалинг салбараар авч үзвэл уул уурхайн салбарын цалин хамгийн өндөр буюу дунджаар 5.7 сая

Зураг 1.6. Дундаж цалин


1. ААН-ийн дундаж цалин, салбараар
(мянган төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1.7. Аж ахуйн нэгж

2. Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо
(мянга)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

⁷ Голч цалин нь ажиллагчдын цалинг өсгөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм.

төгрөгт хүрсэн нь улсын дунджаас 2.5 дахин их байна. Харин зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын дундаж цалин хамгийн бага буюу 1.4 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 1.6 дахин бага байна.


21. Дотоод эдийн засгийн идэвхжил, гадаад эрэлтийн өсөлт ААН-ийн үйл ажиллагааг идэвхжүүллээ. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо 99.1 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өслөө. Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 2.4 мянгаар, тэр дундаа тус салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт ААН-ийн 76 хувийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт ААН 1.1 мянгаар нэмэгдсэн байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарт 1-9 ажилтантай ААН-үүд нэмэгдсэн бол дунд, болон том аж ахуйн нэгжүүд тус салбарт эсрэгээрээ буурах хандлага ажиглагдаж байна. Уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо уул уурхайн салбарт 47, тээврийн салбарт 282-оор нэмэгдлээ. Ажиллагчдын тоогоор уул уурхайн салбарт 1-9 ажиллагчидтай 34 ААН, 10-19 ажиллагчидтай 6 ААН, 20-49 ажиллагчидтай 3 ААН, 50-аас дээш ажиллагчидтай 4 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Харин тээврийн салбарт 1-9 ажиллагчидтай ААН-үүд нэмэгдсэн ч дунд болон том

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор

Ажилчдын тооны бүлэг	ААН тоо, мянга	Өөрчлөлт, хувь	Тайлбар
1-9	84.4	6.1%	Өсөлтийн 2/3-ыг үйлчилгээний салбар бүрдүүлсэн.
10-19	7.1	3.9%	Өсөлтийн 1.4 нэгж хувийг ХАА, 1.3 нэгж хувийг үйлчилгээ, 0.8 нэгж хувийг барилгын салбар бүрдүүлсэн.
20-49	4.9	0.5%	Шинээр 22 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 17 ААН барилгын салбарт байна.
50-иас дээш	2.8	2.0%	Шинээр 54 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 38 ААН үйлчилгээ, 8 ААН барилга, 4 ААН уул уурхай, 3 ААН боловсруулах салбарт байна.
Нийт	99.1	5.9%	

ААН-үүд буурчээ. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарт шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн 551 аж ахуйн нэгжийн 201 нь газар тариалан, 74 нь мал аж ахуй, 306 нь мод тарих үйл ажиллагаанд хамаарч байна. Мөн боловсруулах үйлдвэрлэлд 407 ААН, барилгын салбарт 467 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна (Зураг 1.7). Барилгын салбарт дунд болон том ААН-үүд бусад салбаруудтай харьцуулахад хамгийн ихээр нэмэгдсэн байна.

22. ААН-ийн борлуулалтын орлогын өсөлтийн дийлэнхийг үйлчилгээний салбар бүрдүүллээ. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ААН-ийн бодит борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өсөж 22.7 их наяд төгрөгт хүрлээ. Уг өсөлтийн 15.7 нэгж хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн бөгөөд тэр дундаа тус салбарын гол хэсгийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбар өсөлттэй байсан нь ААН-ийн борлуулалтын орлогыг нэмэгдүүллээ. Зураг (1.8).



ШИГТГЭЭ 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Ажиллах хүчний оролцооны түвшин дэлхийн улс орнуудад цар тахлын нөлөөгөөр хэрхэн өөрчлөгдсөнийг Зураг 1.9-д тоон мэдээлэл нь олдоцтой зарим улсуудыг төлөөлөл болгон авч 2019 (цар тахлын өмнө), 2021 (цар тахлын үе), 2024 (цар тахлын дараа) оны түвшнээр дүрсэлж харуулав. Зургаас харвал цар тахлын үеэр улсуудын ажиллах хүчний оролцоо хөгжлийн түвшнээс үл хамааран ерөнхийдөө буурсан байна. Харин цар тахлын дараа яаж өөрчлөгдсөнийг 2024 оны тоон мэдээллээс харвал зарим улсуудад, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад хөдөлмөр эрхлэлт сэргэсэн байдал ажиглагдаж байхад зарим улсад цар тахлын үеэсээ ч буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт тогтмол үзүүлдэг Вьетнам, Казакстан, Хятад, Солонгос зэрэг улсууд ажиллах хүчний оролцооны түвшнийг 63-70 хувьд хадгалсаар байна. Манай улсын тухайд цар тахлын өмнө АХОТ 61 хувь байсан бол цар тахлын үеэр 57 хувь болж буурсан байдаг. Харин цар тахлыг амжилттай даван эдийн засаг сэргэж, идэвхэжсэнээр хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж 2024 оны 2 дугаар улирлын байдлаар АХОТ 62.2 хувьд хүрсэн нь 2015 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болоод байна.

Энэ үзүүлэлтийг жил бүр 1 нэгж хувиар ахиулан 2028 онд 65 хувьд хүргэхээр тооцвол (ажилгүйдлийн түвшинг трендээ хадгална гэж үзэв) ирэх 4 жилийн хугацаанд ажилчдын тоог жилд дунджаар 47 мянгаар нэмэгдүүлж, тус хэмжээний ажлын байрыг шинээр бий болгох шаардлагатай байна. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар манай улсад 1,347 мянган хүн ажиллаж байна. Ажиллах хүчний оролцооны түвшинг 4 жилийн дараа 65 хувьд хүргэхийн тулд нийт 190 мянган ажилчид нэмж шаардагдах бөгөөд эдгээр ажилчдыг их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдөөс 80 мянга, ажиллах хүчнээс гадуур бусад хүн амаас 110 мянган хүнээр бүрдүүлэхээр байна. Үүний тулд:

- Ахмадууд, оюутнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүн/хүүхэд асарч буй хүмүүс, мэргэжил, дадлага туршлагагүй зэрэг ажиллах хүчнээс гадуур хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажлын байрныхаа 2 хувьд ахмад настан ажиллуулах, 4 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах, оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, хүүхэд харах, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, асрахуйн эдийн засгийг дэмжих, цахимаар зайнаас, болон богино хугацаанд хөдөлмөрлөх боломжийг бүрдүүлэх, төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, дадлагажуулах, КООСЭН сургалтын коллежийг нэвтрүүлэх зэрэг бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 4 жилийн ЗГҮАХ-т тусгасан байна.


Манай улсад 2025–2028 онд 1 жилд ойролцоогоор 30 мянган хүн өндөр насны тэтгэвэрт гарах хүлээлттэй байгаа бол 50 мянган оюутан шинээр төгсөж, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэхээр байна. Эдгээр төгсөгчдөөс тэтгэвэрт гарсан сул ажлын байранд 30 мянга нь ажиллана гэж үзвэл үлдсэн 20 мянган төгсөгчдөд шинэ ажлын байр шаардлагатай болох юм. Үүн дээр нэмээд ажиллах хүчнээс гадуур хүн амаас ажилчид орж ирэн нийт ажилчдын тоог нэмэгдүүлнэ гэж үзвэл жилд дунджаар 47 мянган шинэ ажлын байр бий болгох шаардлагатай байна. Энэ нь сүүлийн 4 жилийн байдлаар жилд дунджаар 48 мянган шинэ ажлын байрны эрэлт бий болж байгаа талаар Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар⁸ гарсан үр дүнтэй нийцтэй байна. Иймд:

- Ажлын байр нэмэгдүүлэх хүрээнд эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтыг дэмжих, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэхийн зэрэгцээ оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайн ажлын байрыг нэмэгдүүлэх “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг хэрэгжүүлэх, тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжих, 1,000 өндөр технологийн ажлын байр бий болгох гэх мэт бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

⁸ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс жил бүр хийгддэг судалгаа

Зураг 1.9. Ажиллах хүчний оролцооны түвшин

(цар тахлын өмнөх, одоо, дараах үе, улсуудаар)



Эх сурвалж: Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, ЭЗХАХБ, ҮСХ * 2024 оны АХОТ-г тухайн улсын боломжит сүүлийн үеийн тоон мэдээллийг ашиглан оруулав

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ


23. Хөдөлмөрийн зах зээлийн сэргэлтийн нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдлаа. 2024 оны 2 дугаар улиралд ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 46 мянган хүнээр, өмнөх улирлаас 12 мянган хүнээр тус тус өсөж хөдөлмөрийн зах зээл сэргэсний нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт 4 орчим хувьд хадгалагдлаа. Мөн 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон машин, тоног төхөөрөмж 179 тэрбум төгрөгөөр нэмэгдэж үндсэн хөрөнгийн хуримтлалд 2 улирал дараалан эерэг нөлөө үзүүллээ. Гэсэн хэдий ч том малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрч, мал хөрөнгө 387 тэрбум төгрөгөөр, барилга байгууламж 90 тэрбум төгрөгөөр буурснаар нийт үндсэн хөрөнгө 2024 оны 2 дугаар улиралд 349 тэрбум төгрөгөөр буурлаа.

24. Хөдөө аж ахуйн салбарын агшилт үйлдвэрлэлийн сөрөг зөрүүг нэмэгдүүллээ. Оны эхний улиралд уул уурхайн олборлолт, хөрөнгө оруулалтын өсөлт дагасан дотоод эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдах хандлагатай байсан ч хөдөө аж ахуйн салбарын агшилтын нөлөөгөөр сөрөг зөрүү тэлж 2024 оны 2 дугаар улиралд потенциал түвшнээсээ 1.0 нэгж хувиар доогуур гарлаа. Цаашид дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, хөдөө аж ахуйн салбарын агшилтын ДНБ-д үзүүлэх нөлөө алгуур буурснаар үйлдвэрлэлийн сөрөг зөрүү оны төгсгөлд хаагдах төлөвтэй байна.

25. Төгрөгийн ханш чангарч, үйлдвэрлэлд ашиглагдах импортын орцын зардал буурснаар хөдөлмөрийн зах зээлд эергээр нөлөөлж байна. Үйлдвэрлэлийн бодит ахиу зардал нь үйлдвэрлэл явуулахад шаардлагатай орцын зардлыг илэрхийлэгч хувьсагч юм. Манай улсын нийт импортын 60 орчим хувь нь үйлдвэрлэлд ашиглагддаг бөгөөд төгрөгийн ханш чангарах нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулах нөлөөтэй байдаг. 2024 оны 2 дугаар улиралд төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс 2 хувиар чангарснаар үйлдвэрлэлийн бодит зардал 5 хувиар буурлаа. Зардал буурч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа сэргэснээр ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 4 хувиар өсөж, хөдөлмөрийн зах зээл сэргэж байна.


Зураг 1.10. Үйлдвэрлэлийн зөрүү

1. Потенциал ДНБ-ий өсөлт
(нэгж хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг Ходрик-Прескотт, Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тус тус тооцов.


2. Үйлдвэрлэлийн зөрүү
(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг үйлдвэрлэлийн функцийн аргаар тооцов. ҮСХ-ноос зарласан 2022 оны 1 дүгээр улирлаас 2024 оны 2 дугаар улирал хүртэлх үндсэн хөрөнгийн хэмжээ болон ажиллагчдыг тооцох аргачлалд өөрчлөлт орж үйлдвэрлэлийн зөрүүг 2024 оны 2 дугаар улиралд шинэчлэн тооцов.

3. Үйлдвэрлэлийн бодит ахиу зардал болон ажиллагчдын хөдөлгөөн

(сая хүн: баруун тэнхлэг, хувь: зүүн тэнхлэг)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн бодит ахиу зардлыг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загвар дах Филиппсийн муруйн тэгшитгэлээс тодорхойлол

БҮЛЭГ 2

ТӨСВИЙН СЕКТОР

- 2.1 ТӨСВИЙН БОДЛОГО
- 2.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН
ТОГВОРТОЙ БАЙДАЛ

2. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Дотоод эдийн засгийн идэвхжил, нүүрсний эрэлт өссөн зэрэг эрэлтээс үүдэлтэй төсвийн орлого нэмэгдсэнээр төсвийн нийт тэнцэл 2024 оны 2 дугаар улиралд 57.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан хэдий ч үүнээс улирлын нөлөөг арилгавал 40.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон нутагт ажиллах, амьдрах таатай орчныг бүрдүүлэхтэй холбоотойгоор төрийн албан хаагчийн цалинг тэр дундаа орон нутагт ажиллаж, амьдарч байгаа албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн нь өрхийн бодит орлого 2024 оны эхний хагас жилд 17.3 хувиар өсөхөд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн өрийн үлдэгдэл ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 38.3 хувьд хүрч нэмэгдсэн нь өрийн тогтвортой байдлыг хангаж байгаа ч нийслэлийн гадаад, дотоод зах зээлд гаргасан үнэт цаастай холбоотойгоор дунд хугацаанд Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэх хүлээлттэй байна.

ТӨСВИЙН БОДЛОГО


26. Төсвийн орлого өсөхөд дотоод эдийн засгийн идэвхжил өндөр байж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Төсвийн орлого 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.2 хувиар өслөө. Эдийн засгийн дотоод эрэлт идэвхжиж, 2024 оны эхний хагас жилд төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 46.9 хувиар, өрхийн хэрэглээ 16.9 хувиар тус тус тэлсэн байна. Үүний нөлөөгөөр НӨАТ-ын орлого 2024 оны эхний хагас жилд 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө (Зураг 2.1). Түүнчлэн, БНХАУ-ын нүүрсний үйлдвэрлэл буурснаар эрэлт нь өсөж, нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны эхний хагас жилд 40.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн нөлөөгөөр тус салбарын аж ахуй нэгжүүдийн орлого өсөж, улмаар ААНОАТ-ын орлого өнгөрсөн оны мөн үеэс 74.4 хувиар, АМНАТ-ийн орлого 21.7 хувиар тус тус өссөн байна. (Зураг 2.1)

27. Цалин, тэтгэврийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлсэн нь өрхийн орлогод эергээр нөлөөллөө. Төсвийн нийт зарлага 2024 оны эхний хагас жилд 12.9 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 42.9 хувиар өссөн байна. Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төрийн албаны шинэчлэлийг хийх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах бодлогын хүрээнд 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг дунджаар 40 хувиар, 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар тус тус үе шаттайгаар нэмэгдүүлсэн. Түүнчлэн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлээд байна. Эдгээр бодлого, арга хэмжээнүүд өрхийн бодит орлого 17.3 хувиар өсөхөд нөлөөллөө.

28. Эхний хагас жилийн байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл удаашралтай байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар


Зураг 2.1. Төсвийн орлого

(их наяд төгрөг: зүүн тэнхлэг, хувь: баруун тэнхлэг)



Зураг 2.2. Төсвийн зарлага

(их наяд төгрөг: зүүн тэнхлэг, хувь: баруун тэнхлэг)



хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 15.5 хувьтай байна. Гүйцэтгэл бага байгаа нь шилжин хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх явц удааширч, батлагдсан санхүүжилтээ бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг гүйцэтгэлийн явц сайн үргэлжилж буй төсөл, арга хэмжээнд нэмж санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өмнөх оноос давсан гүйцэтгэлийг санхүүжүүлэх шаардлага үүсээгүйтэй буюу зарим төслүүд хугацаанаас өмнө ашиглалтад орох боломжийг бүрдүүлсэнтэй холбоотой байна.


29. Төсвийн нийт тэнцэл 2024 оны 2 дугаар улиралд 57.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан хэдий ч үүнээс улирлын нөлөөг арилгавал 40.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Эдийн засаг тэлж, эдийн засгийн мөчлөгийн нөлөөг илэрхийлэх автомат тогтворжуулагчийн нөлөө эерэг байсан хэдий ч мөчлөг дагасан төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлсэн нь төсөв алдагдалтай гарах гол шалтгаан болж байна. Тус алдагдалд нөлөөлөх төсвийн бодлогоос шалтгаалах нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос үл хамаарах эдийн засгийн мөчлөгийн нөлөөг автомат тогтворжуулагчаар, өрийн дарамтыг хүүгийн зардлаар илэрхийлэн зураг 2.3-г харуулав. Улирлын нөлөө арилгасан нийт тэнцэл алдагдалтай гарахад төсвийн тэлэлттэй холбоотой төсвийн бодлогын нөлөө -309.4 тэрбум төгрөг, хүүгийн зардлын нөлөө -193.3 тэрбум төгрөгтэй дүйцэх хэмжээнд сөрөг нөлөө үзүүлсэн бол эдийн засгийн дотоод идэвхжилтэй холбоотой эдийн засгийн мөчлөгийн нөлөө 462.3 тэрбум төгрөгийн эерэг нөлөө үзүүлсэн байна.

Улмаар төсвийн импульс буюу төсвийн төлөвийн жилийн өөрчлөлтөөр тооцсон төсвийн бодлогын далайц 1.3 их наяд төгрөг хүрсэн нь КОВИД-19 цар тахлаас хойших хамгийн өндөр өөрчлөлт болоод байна.

Зураг 2.3. Төсвийн нийт тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч


(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тайлбар: Бүх үзүүлэлтийг тухайн улирлын үзүүлэлтээр тооцов.

Зураг 2.4. Төсвийн төлөв

(хувь)



— Төсвийн төлөв/ Потенциал ДНБ
— Үйлдвэрлэлийн эерүү/ Потенциал ДНБ

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Зураг 2.5. Төсвийн импульс

(их наяд төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


30. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурсан ч өмнөх улирлаас 475.4 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилд 30.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 863 тэрбум төгрөгөөр буурлаа. Засгийн газрын өр буурахад дотоод өр 510 тэрбум төгрөгөөр, болзошгүй өр төлбөр 490 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь эерэг нөлөө үзүүлсэн. Гэсэн хэдий ч Засгийн газрын өр өмнөх улирлаас 475.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Засгийн газрын өрийн баталгаа 225.3 тэрбум төгрөгөөр, орон нутгийн зээллэг 500 тэрбум төгрөгөөс тус тус нэмэгдсэн нь өр өмнөх улирлаас нэмэгдэх үндсэн шалтгаан боллоо.

31. Богино хугацаанд бондын эргэн төлөлтэй холбоотой өрийн төсөвт үзүүлэх дарамт бага байна. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8,716 тэрбум төгрөг байна. Олон улсын зах зээлд 2020 оноос хойш арилжаалсан Номад, Сенчири-2027, Сенчири-2028, Сенчири-2029, Сенчири-2031 үнэт цааснуудыг зөвхөн өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан байна. Сенчири өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2022-2024 онд төлөгдөх хуваарьтай байсан Чингис, Гэрэгэ, Хуралдай бондуудын нийт 2,200 сая ам.долларын төлбөрийг барагдуулсан бөгөөд үүнээс 281 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлсөн байна. Гадаад үнэт цаасны төлбөр 2026 оныг хүртэл байхгүй хэдий ч тус оноос эхлэн 5 жилийн хугацаанд эргэн төлөгдөх хуваарьтай 2.6 тэрбум ам.долларын дүн бүхий эргэн төлөлт хүлээгдэж байна.

32. Засгийн газрын өрийн хэмжээнд гадаад зээлийн эзлэх хэмжээ өндөр байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар гадаад зээл Засгийн газрын гадаад өрийн 70 хувийг, Засгийн газрын нийт өрийн 68 хувийг эзэлж байна. Гадаад зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 334 тэрбум төгрөгөөс өсөж 20,630.2 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн үед гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт буюу гадаад зээлийн хүүгийн төлбөрт 582.0 тэрбум төгрөг төлсөн ба энэ онд нийт 2,719.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр


Зураг 2.6. Засгийн газрын өр

1. Засгийн газрын өрийн хэмжээ




Эх сурвалж: Сангийн яам

2. Засгийн газрын өрийн хэмжээ



Эх сурвалж: Сангийн яам

3. Гадаад бондын эргэн төлөлтийн хуваарь



Эх сурвалж: Сангийн яам


төлөхөөр хүлээгдэж байна. Түүнчлэн сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 1,941.2 тэрбум төгрөгийг гадаад хүүгийн төлбөрт төлсөн байна. 2024 онд гадаадын зээл тусламжаар нийт 106 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд үүний 44 нь цахилгаан, дулааны хангамжтай холбоотой бүтээн байгуулалт байна.

33. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үндсэн тэнцлийн⁹ нөлөө өндөр байна. Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд хэр мэдрэг байгааг харуулах боломжтой. Тус тооцооллоор голлох үзүүлэлтүүдийн тухайлсан нөлөөг үнэлэх үүднээс 1) бодлогын болон бүтцийн өөрчлөлт байхгүй; 2) шокийн нөлөө тооцсон хувьсагчаас бусад хувьсагчийг тогтмол; 3) шокийн нөлөө тооцсон оноос бусад онд суурь түвшин өөрчлөгдөхгүй гэж үзэв. Суурь төсөөллөөр 2024-2027 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 5.6, 8.0, 6.5, 6.5 хувьд, инфляц 6.5, 7.5, 5.0, 4.0 хувьд, ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, үндсэн тэнцэл төсөөллийн орчимд бусад макро үзүүлэлтүүд 2023 оны түвшинд тогтвортой байхад 2027 онд Засгийн газрын өр ДНБ-ий 42.7 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдийн шокийн нөлөөг 2025, 2026 онуудад 1 стандарт хазайлтаар тооцов. Үнэлгээний үр дүнд дээрх шокийн нөлөө тохиолдсон үед Засгийн газрын өрийн хэмжээ 2027 онд суурь түвшнээс 15.4 хувь, 28.8 хувиар өсөх магадлал харилцан 25 хувь байна.


34. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцлийг ашигтай түвшинд хадгалах нь чухал байна. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлж, зураг 2.7-д харууллаа. ДНБ-д эзлэх Засгийн газрын нэрлэсэн өрийн хэмжээ 2016 онд 30.6 хувиар өссөн ба үндсэн тэнцлийн алдагдал түс өсөлтийн 11.2 нэгж хувийг бүрдүүлсэн бол 2020 онд

Зураг 2.7. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

1. Засгийн газрын өр ба нэрлэсэн гадаад хүүгийн, валютын ханшийн сөрөг шокийн нөлөө



2. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс



10.1 хувийн өсөлтийн 6.9 нэгж хувийг бүрдүүлсэн байна. 2023 онд Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 15.8 хувиар буурахад бодит хүүгийн өөрчлөлт 6.4 нэгж хувийг тайлбарлаж байгаа бол үндсэн тэнцлийн ашиг 4.3 нэгж хувийг тайлбарлаж байна. Цаашид өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт, үндсэн тэнцлийн алдагдал голлох нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.

⁹ Үндсэн тэнцэл –Нийт зарлагаас хүүгийн төлбөрийг хасаж тооцсон дүнг хэлнэ. Үндсэн тэнцлийн улирлын шинж чанараас шалтгаалан гарах хэлбэлзлийг хассан буюу улирлын нөлөө арилгасан дүнгээс төсвийн төлөвийг тодорхойлдог. Улирлын нөлөө арилгасан үндсэн тэнцэл эерэг бол төсвийн хумих бодлого, сөрөг бол төсвийн тэлэх бодлогыг илэрхийлнэ.

ШИГТГЭЭ 3. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР

Улсын Их хурлын 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит бус чуулганы хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Тус хуулийн өөрчлөлтөөр дараах төсвийн тусгай шаардлагуудад өөрчлөлт оруулаад байна.

Хүснэгт 2. Төсвийн тусгай шаардлага, түүний өөрчлөлт

Төсвийн тусгай шаардлага	Өмнө мөрдөгдөж байсан хуулиар	2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн өөрчлөлт	2024 оны Төсвийн тодотголын өөрчлөлт
Төсвийн орлого	Олон улсын байгууллагаас тооцролсон голлох уул уурхайн бүтээгдэхүүний ирэх жилүүдийн үнийн төсөөллийг дундажлан төсвийн орлогыг тооцоолох	Өөрчлөлтгүй	Өөрчлөлтгүй
Төсвийн зарлага	Уул уурхайн бус салбарын өмнөх жилийн өсөлт болон сүүлийн 12 жилийн дундаж өсөлтөөс хэтрэхгүй байх	Өөрчлөлтгүй	<ul style="list-style-type: none"> Төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй байх. Төсвийн нийт зарлагын өсөлтийг уул уурхайн бус салбарын өсөлтөөр хязгаарлахгүй.
Төсвийн тэнцэл	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх	2025 оноос эхлэн Төсвийн алдагдлын хязгаарыг байхгүй болгосон.	<ul style="list-style-type: none"> Тэнцвэржүүлсэн тэнцлийн хязгаар өөрчлөгдөөгүй. Төсвийн суурь тэнцлийг нэмэлтээр тооцдог болно. Төсвийн суурь тэнцлийг ДНБ-ий 2 хувь болон түүнээс дээш хувийн ашигтай байлгах.
Засгийн газрын өр	Засгийн газрын өрийн хэмжээг өнөөгийн үнэ цэнээр тооцож, хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх	Засгийн газрын өрийн хязгаарыг 2025 оноос эхлэн ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх	Засгийн газрын өрийг нэрлэсэн дүнгээр тооцож, хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх


1. Төсвийн нийт зарлагын өсөлтийг хязгаарласан заалтыг хүчингүй болгож, урсгал зардлыг ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй байх.

Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ сүүлийн 10 жилийн дунджаар ДНБ-ий 25.4 хувьтай тэнцүү байна. Дээрх хуулийн өөрчлөлтөөр төсвийн урсгал зардлын хэмжээг ДНБ-ий 30 хувь байхаар хязгаарлаж нэмэгдүүлж байгаа нь богино хугацаанд төсвийн урсгал зардал тэлснээр эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж, хувийн хэвшлийн үйл ажиллагаа хумигдах эрсдэлтэй байна. (Зураг 2.8)


2. Төсвийн суурь тэнцлийг тооцдог болж, суурь тэнцлийг ДНБ-ий 2 хувь болон түүнээс дээш хувийн ашигтай байлгах.

Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг тооцохдоо нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос суурь зарлагыг хасаж тооцно. Нэгдсэн төсвийн суурь зарлага гэж нийт зарлагаас “үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг” хасаж тооцсон дүнг хэлнэ гэж тодорхойлсон. Ингэснээр төсвийн тогтворгүй байдал, зах зээл дэх төрийн оролцоо болон өрийн хэмжээ нэмэгдэх, төсвийн сахилга бат алдагдаж, улсын зээлжих зэрэглэл буурах, Засгийн газар болон орон нутгийн төсвийн захирагч нар хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх зорилгоор хэт их үнэт цаас гаргаж санхүүгийн зах зээлийн тэнцвэр алдагдах, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй байна.

Зураг 2.8. Урсгал зардал
(ДНБ-д эзлэх хувь)



Зураг 2.9. Төсвийн тэнцэл
(хувь: баруун тэнхлэг, их наяд төгрөг: зүүн тэнхлэг)



3. Засгийн газрын өрийг нэрлэсэн дүнгээр тооцож, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дэлхийн өв сан байгууллагаас зарладаг Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн "Төсвийн сахилга бат" үзүүлэлтээр тухайн улсын ДНБ-д эзлэх өрийн хэмжээг сүүлийн 3 жилийн дунджаар тооцон харуулдаг бөгөөд Монгол Улсын хувьд дээрх үзүүлэлт 2023 оны байдлаар 71.9 хувьтай буюу дэлхийн 195 орноос 125 дугаар байрт жагсаж байна. Тус үнэлгээгээр дэлхийн эхний хагаст багтахын тулд манай улс Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээг 50 хувиас хэтрүүлэхгүй байхаар хязгаарлаж цаашид өрийн ДНБ-д эзлэх хэмжээг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Хүснэгт 3. Засгийн газрын өр

ҮЗҮҮЛЭЛТ	2019	2020	2021	2022	2023	2024.II
ЗГ-ын өр, нэрлэсэн дүнгээр, их наяд ₮	24.1	27.9	26.9	32.0	30.7	30.2
ДНБ-д эзлэх хувь	65.3%	75.5%	62.6%	60.5%	44.6%	38.3%
ЗГ-ын өр, ӨҮЦ-ээр, их наяд ₮	20.5	23.0	21.8	27.7	26.5	26.2
ДНБ-д эзлэх хувь	55.6%	62.3%	50.8%	52.4%	38.5%	33.2%


Эх сурвалж: Сангийн яам

ШИГТГЭЭ 4. ТӨСВИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ ЦАХИМЖУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Сүүлийн 2 жилийн хугацаанд цахимжилт, технологийн дэвшлийг ашиглан татварын бааз суурийг нэмэгдүүлэх, төсвийн зарлагын хяналтыг сайжруулах зэргээр төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бараа ажил үйлчилгээг татварын бүртгэл мэдээллийн системтэй уялдуулах замаар НӨАТ-ын тайлагналтыг сайжруулах, төсвөөс гарч буй аливаа мөнгөн гүйлгээг цахим төлбөрийн баримтын тогтолцоонд шилжүүлснээр төсвийн орлого бүрдүүлэлт сайжирсан. (Зураг 2.10)
- Төсвийн зарлагын хяналтыг сайжруулахад төсвөөс санхүүждэг ААН-үүдэд татварын бүртгэлийн мэдээллийн системд зайлшгүй холбогдсон байх шаардлагыг системээр тавьж, татварын орлогын урсгалыг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар төсвөөс санхүүждэг 4,939 байгууллагатай харьцаж ажилласан 51,199 бизнес эрхлэгч 2.3 их наядын борлуулалтын орлогоо мэдүүлсэн бол 2024 он эхний хагас жилд 56,946 ААН 3.1 их наядын борлуулалтын орлогоо мэдүүлснээр НӨАТ, ААНОАТ, ХХОАТ дээр ногдол нэмэгдэх боломж бүрдээд байна. (Зураг 2.10)
- Онцгой албан татвартай бараа (архи согтууруулах ундаа, тамхи) бүтээгдэхүүний эргэлтэд хяналт тавих хуулийн хүрээнд дотоодын болон импортын бараа бүтээгдэхүүнд ногдох онцгой албан татварыг төвлөрүүлэхэд СЯ, ХХААЯ, ТЕГ, ГЕГ зэрэг байгууллагууд харилцан мэдээлэл солилцох замаар гарал үүслийг тогтоох, бараа тутамд зөвшөөрлийн гэрчилгээг цахимаар олгох, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах, татварын тайлагналтыг автоматжуулах ажлууд хийгдэж байна. (Зураг 2.10)

Зураг 2.10. Татварын орлого



БҮЛЭГ 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1 ИНФЛЯЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГО

3.2 САНХҮҮГИЙН САЛБАР

3. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц үргэлжлэн буурч, 2024 оны 6 дугаар сарын байдлаар 5.1 хувь болж, төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа. Хэрэглээний сагсан дахь зарим импортын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээл дээрх үнэ буурч, төгрөгийн ханшийн сулрал тогтворжсон нь импортын инфляц саарахад нөлөөллөө. Улмаар төв банкнаас бодлогын хүүг оны эхний хагас жилд 2 удаа тус бүр 1 нэгж хувиар бууруулж 11 хувьд хүргэсэн. Инфляцын бууралтаас шалтгаалж бодит үйлчилж буй зээл болон хадгаламжийн дундаж хүүгийн зөрүү буурч байна.

Бодлогын хүү буурч, эдийн засгийн идэвхжил хадгалагдсанаар банкнуудын зээл олголт нэмэгдсэн бол өрхийн бодит орлого нэмэгдсэнээр төгрөгийн хадгаламж өссөн байна. Зээлийн өсөлт болон эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр арилжааны банкнуудын чанаргүй зээл харьцаа 5.8 хувь хүртэл буурч сүүлийн 35 улирлын түүхэнд хамгийн бага түвшинд хүрлээ.

ИНФЛЯЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГО


35. Инфляцын буурах хандлага үргэлжилж 2024 оны 2 дугаар улиралд улсын хэмжээнд 5.1 хувь хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурлаа. Инфляц 5.1 хувь болоход хүнсний бараа 1.4 нэгж хувь, боловсролын үйлчилгээ 0.7 нэгж хувь, хувцас, бөс бараа, гутал 0.6 нэгж хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 0.5 нэгж хувийг бүрдүүлж, голлон нөлөөлсөн байна. Инфляц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсны 3.7 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 0.7 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.3 нэгж хувийг гэр ахуйн тавилга, бараа, 0.3 нэгж хувийг тээвэр бүрдүүлсэн бол боловсролын үйлчилгээ 0.4 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлсэн байна.

36. Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц саарах хандлага үргэлжилсний зэрэгцээ дотоодын бараа, үйлчилгээний инфляц тогтворжив. Өмнөх оны мөн үед 8.3 хувь байсан импортын гаралтай инфляц 3.9 хувь болж, 4.4 нэгж хувиар буурсан байна. Энэ нь нийт инфляцын 35.3 хувийг бүрдүүллээ. Хэрэглээний сагсан дахь зарим импортын барааны үнэ гадаад зах зээлд буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой хадгалагдсан нь импортын инфляц саарахад голлон нөлөөлөв. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц өмнөх оны мөн үед 12.6 хувь байсан бол 2024 оны 2 дугаар улиралд 6.1 хувь болж, 6.5 нэгж хувиар буурав. Энэ нь нийт инфляцын 64.7 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын инфляц саарахад хүнсний бүтээгдэхүүн болон үйлчилгээний үнийн өсөлт саарсан нь голлох нөлөө үзүүлжээ.

37. 2024 оны 2 дугаар улиралд хүнсний болон хүнсний бус инфляцын буурах хандлага хадгалагдсан хэвээр байлаа. Өмнөх оны мөн үед 18.2 хувь байсан хүнсний инфляц 4.8 хувь болж бууран, нийт инфляцын 28 хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний үнийн өсөлтийн 93 хувийг талх, гурил, будаа, сүү, өндөг, хүнсний ногооны үнийн өсөлт тайлбарлаж байна. 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн импортлох улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр импортын гурилын нийлүүлэлт нэмэгдсэн хэдий ч дотоодын гурилын үнэ сар бүр 0.3-2.5 хувиар өслөө. Харин мах, махан бүтээгдэхүүний


Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн

1. Инфляц ба зорилтот түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Улирлын инфляцын хувь хэмжээг улирлын сүүлийн саруудаар тооцов.

2. Инфляцын бүрэлдэхүүн



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Инфляцад өндөр хувь нэмэртэй бараа болон бүлгээр нийт инфляцыг задлан харуулав.

3. Суурь инфляц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Суурь инфляцыг хүнс, шатахуун ба хатуу түлшийг нийт инфляцаас хасаж тооцов.

үнэ 2023 оны өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурсан байна. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 5.2 хувь хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 нэгж хувиар буурав. Энэ нь нийт инфляцын 72 хувийг бүрдүүлээ. Хүнсний бус инфляцад хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 5.4 хувиар, орон сууц, ус, цахилгаан болон түлшний бүлгийн үнэ 4.7 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 6.6 хувиар өссөн нь нөлөөллөө.

38. Нийт инфляцын 68 хувийг эрэлтийн гаралтай инфляц, 32 хувийг нийлүүлэлтийн гаралтай инфляц бүрдүүлэв. Өмнөх оны мөн үед 8.2 хувь байсан эрэлтийн (суурь) инфляц 5.2 хувь болж, 3.0 нэгж хувиар буурсан байна. Төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт эрэлтийн инфляцад хүлээлтээс багаар нөлөөлж буурах хандлагатай байсан хэдий ч нийт инфляцын 68 орчим хувийг бүрдүүлэв. Мөн өмнөх оны өндөр өсөлттэй суурь үеийн нөлөө арилсан болон төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой хадгалагдсан нь эрэлтийн инфляц буурахад нөлөөлжээ. Нийлүүлэлтийн гаралтай инфляц өмнөх оны мөн үеэс 10.6 нэгж хувиар буурч, 4.8 хувьд хүрсэн байна.

39. Хүнсний барааны үнийн өсөлт саарсан нь Улаанбаатар хотын инфляц буурахад голчлон нөлөөлөв. Улаанбаатар хотын инфляц 4.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурлаа. Инфляцын бууралтын 3.5 нэгж хувийг хүнсний бараа,

0.8 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 0.5 нэгж хувийг тээврийн бүлэг бүрдүүлсэн байна. Хүнсний үнийн өсөлт буурахад өнгөрсөн оны мөн үед дотоодын зарим хүнсний бүтээгдэхүүний үнэ өндрөөр өсөж байсан суурь үе голлон нөлөөлөв. Тухайлбал, махны инфляцад үзүүлэх нөлөө 2.8 нэгж хувиар, талх, гурил, будааны инфляцад үзүүлэх нөлөө 1.0 нэгж хувиар тус тус буурчээ. Харин боловсролын үйлчилгээний үнэ өнгөрсөн оны 8 дугаар сард 21.2 хувиар өссөн нь Улаанбаатар хотын инфляцыг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлээ.

40. Олон улсад чингэлэг тээврийн үнэ өндөр хэвээр байсан ч хүнсний үнийн индекс буурлаа. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2024 оны 2 дугаар сараас эхлэн эрчтэй өсөөд байсан бол 8 дугаар сард буурч 40 фут чингэлэг тутам 5,428 ам.долларт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 196 хувиар, Ковид-19 цар тахлын өмнөх үеийн дунджаас 282 хувиар өндөр үзүүлэлт юм. 2024 оны 7 дугаар сард хүнсний үнийн индекс 120.8 болж, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурчээ. Дэлхийн зах зээл дээр сүүлийн сар ургамлын тос, мах, элсэн чихрийн үнэ өссөн бол үр тарианы үнэ буурч, сүүн бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөөгүй байна. Дэлхий дахинд инфляц буурах хандлага үргэлжилж, хөгжингүй болон хөгжиж буй орнуудын инфляц төв банкны зорилтот түвшин рүү ойртсоор байна. Сүүлийн сар Киргизстан, Америк, Турк, Гүрж улсуудын инфляц буурсан бол Хятад, Орос, Солонгос, Япон, Казакстан, Евро бүс, Шри-Ланк, Их-Британи улсуудын инфляц өсжээ.

41. Мөнгөний бодлогын хүү эдийн засгийн төлөв байдалтай нийцэж зохистой түвшинд байна.


Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрээр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэсэн. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар бодлогын хүүгийн зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүү 12.0 хувь байгаа нь төв банкны хоёрдугаар улирлын дундаж бодлогын хүү 11.3 хувиас бага зэрэг өндөр байна. Банкнудын шинээр олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс өсөхийн зэрэгцээ Тяньжин боомт дээрх чингэлгийн бөөгнөрлөөс үүдэлтэйгээр импортын барааны нийлүүлэлт тасалдах, улмаар инфляц өсөх эрсдэлтэй байгаа тул бодлогын хүүг богино хугацаанд бууруулахгүй байх нь тохиромжтой байна.

42. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн жил мөнгөний богино хугацааны зорилтот өсөлтөөс өндөр байлаа.

Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт зохистой түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог мөнгөний илүүдэл өсөлт 2024 оны 2 дугаар улиралд тооцооллоор 3.2 хувь хүрсэн нь мөнгөний богино хугацааны зорилтот өсөлт урт хугацааны зорилтот өсөлтөөс их байгааг илтгэж байна. Хэдийгээр мөнгөн хөрөнгийн илүүдэл сүүлийн 2 улирал дараалан буурсан боловч эерэг хэвээр байгаа нь мөнгөний нийлүүлэлт тэнцвэрт түвшнээс өндөр байгааг илэрхийлж байна.


Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний зорилтот өсөлт

1. Бодлогын хүү ба Тэйлорын хүү



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Үндэсний статистикийн хороо, Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь Төв банкны бодлогын хүүгийн зохистой утгыг илэрхийлдэг бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү болон тогтмол коэффициентийг агуулсан тэгшитгэл юм.


2. Мөнгөний өсөлт




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Тэмдэглэл: Мөнгөний урт хугацааны өсөлт нь инфляцын зорилтот түвшин, ДНБ-ий трендийн өсөлтийн нийлбэр болон мөнгөний эргэлтийн хурдны трендийн жилийн өсөлтийн зөрүүгээр тодорхойлогдоно. Мөнгөний богино хугацааны зорилтот өсөлт нь урт хугацааны зорилтот түвшин болон мөнгөний илүүдлийн зөрүүгээр тодорхойлогддог.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1. Хонины мах (кг/төгрөг)




2. Үхрийн мах (кг/төгрөг)




3. Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)




4. Талх, Атар (төгрөг)




5. Ургамлын тос (төгрөг)




6. Төмс (төгрөг)



7. Сүү, савласан (литр/төгрөг)



8. Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо
Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.

ШИГТГЭЭ 5. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

Нөхцөл байдал

Монгол Улс 2023 онд өмнөх оноос 6.1 хувиар их буюу 8.5 тэрбум кВт.ц эрчим хүч үйлдвэрлэсэн ч дотоодын хэрэглээний 22 хувийг буюу 2.4 тэрбум кВт.ц эрчим хүчийг импортолсон. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн 5 жилд дунджаар жилийн 6 хувийн өсөлттэй байсан бөгөөд цаашид 5-6 хувиар өсөх төлөвтэй байгаа нь дотоодын эрчим хүчний ачааллыг нэмэгдүүлэхээр байна. Нийт хуваарилагдаж буй цахилгаан эрчим хүчний 80 орчим хувийг иргэд, аж ахуйн нэгжийн хэрэглээнд, 11 хувийг алдагдалд, 9 хувийг цахилгаан станцуудын дотоод хэрэглээнд ашиглагдаж байна.

Монгол Улсын нийт цахилгааны хэрэглээ 2024 оны урьдчилсан төлөвлөгөөгөөр 7.6 тэрбум кВт.ц байна. Нийт цахилгаан хэрэглээний 92 хувийг Төвийн бүс, 4 хувийг Зүүн бүс, 2.8 хувийг Баруун бүс, 1.4 хувийг Алтай-Улиастайн бүс тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Эрчим хүчний өртөг ба тариф, бүс нутгаар

	Төвийн бүс	Зүүн бүс	Баруун бүс	Алтай-Улиастайн бүс
1 кВт.ц цахилгааны өртөг	256 төгрөг	260 төгрөг	358 төгрөг	277 төгрөг
1 кВт.ц цахилгааны дундаж тариф	216 төгрөг	200 төгрөг	169 төгрөг	174 төгрөг
Нэгжийн алдагдал (хувь)	40 төгрөг (-18.5%)	60 төгрөг (-30%)	189 төгрөг (-112%)	103 төгрөг (-59%)

2024 онд Төвийн бүсийн 1 кВт.ц цахилгааны өртөг 256 төгрөг, дундаж тариф 216 төгрөг байгаа бөгөөд нэгж тутмаас 40 төгрөгийн алдагдалтай байна. Мөн 1 кКал дулааны бодит өртөг 63 мянган төгрөг байгаа хэдий ч дундаж үнэ 33.8 мянган төгрөг буюу нэгж тутмаас 46 хувийн алдагдал хүлээж байна. Хэрэв тарифт өөрчлөлт орохгүй тохиолдолд Эрчим хүчний зохицуулах хорооны тооцооллоор 2024 онд эрчим хүчний үйлдвэрлэгч компаниудын алдагдал 274 тэрбум төгрөгт, богино хугацаат өр төлбөр 559 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Иймд, эрчим хүчний салбарын либералчлалын ажлыг хэрэгжүүлж, төрийн оролцоог бууруулж, тус салбарыг зах зээлийн зарчмаар ажилладаг бие даасан салбар болгох шаардлагатай.

Өрхийн сарын дундаж зарлага 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.5 сая төгрөг байгаа бөгөөд цахилгаан, дулааны зардалд 2-3 хувийг зарцуулж байна. Дэлхийн банкны 2024 оны судалгааны үр дүнд Монгол Улсад одоо мөрдөгдөж буй эрчим хүчний тариф, татаас нь хүн амын чинээлэг бүлэгт илүү таатай нөхцөл бүрдүүлэн тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна гэжээ. Дийлэнх бага орлоготой өрхүүд ихэвчлэн төвийн дулаан хангамжгүй гэр хороололд амьдардаг учраас эдгээр өрхөд дулааны хэрэглээ байдаггүй байна.

Харин чинээлэг айл өрхүүд цахилгаан эрчим хүчний хэрэглээ өндөртэйгөөс гадна том метр квадраттай орон сууц, амины орон сууцанд амьдардагтай холбоотойгоор тэдний дулааны хэрэглээ бусад бүлгүүдээс хамгийн өндөр байдаг. Ингэснээр эрчим хүчний татаасны нийт мөнгөн дүнгийн дийлэнх хувийг чинээлэг өрхүүд хүртэж, тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Тариф нэмэгдлийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Одоо мөрдөгдөж буй тарифаар өрхийн цахилгаан, дулааны зардал нийт зарлагын 3 орчим хувийг эзэлдэг. Эрчим хүчний зохицуулах хорооны төлөвлөж буй тарифаар эрчим хүчний үнийг нэмэгдүүлсэн ч цахилгаан, дулааны зардлын өрхийн зардалд эзлэх хувь 5 орчим хүртэл өсөхөөр байгаа тул тарифын шинэчлэлийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөө харьцангуй бага байхаар байна. Мөн аж ахуйн нэгж байгууллагын эрчим хүчний зардал бага буюу нийт зардлын 1.0 орчим хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Нийт зардалд эзлэх цахилгаан, дулааны хувь, салбараар

Салбар	Татвар төлөгчийн тоо	Нийт зардал /тэрбум төгрөг/	Цахилгаан, дулааны зардал /тэрбум төгрөг/	Нийт зардалд эзлэх цахилгаан, дулааны хувь
Худалдаа	37,521	56,040	298	0.5%
Үйлчилгээ	5,497	1,663	90	5.4%
Уул уурхай	702	21,759	42	0.2%
Боловсруулах үйлдвэрлэл	2,561	3,998	39	1.0%
Хөдөө аж ахуй	7,642	4,508	31	0.7%
Мэдээлэл, холбоо	2,224	2,444	19	0.8%
Барилга	1,317	2,808	17	0.6%
Тээвэр	2,709	4,669	16	0.3%
Эрүүл мэнд	1,535	1,281	7	0.6%
Боловсрол	565	390	4	1.0%
Нийт	62,273			1.1%

Эх сурвалж: И-Баримтын мэдээллийн бааз, 2023 он

Тарифын шинэчлэл нь инфляцад шууд эрчим хүчний салбарын үнийн өсөлтөөр болон шууд бусаар бусад салбарын үйлдвэрлэл дэх эрчим хүчний зардлаар дамжин нөлөөлнө. Цахилгаан, дулааны үнэ нэмэгдсэнээр инфляц нийт 2.5 орчим нэгж хувиар өсөхөөр байна. Харин эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн хүчин чадлын дутагдал нь салбаруудын үйлдвэрлэлд ашиглагдах цахилгааныг хязгаарлаж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Суурилагдсан хүчин чадалд шинээр хөрөнгө оруулахгүй үед буюу тоног төхөөрөмж жилд 2 хувиар элэгдэх тохиолдолд 2028 он гэхэд эдийн засгийн өсөлт ердөө 0.2 хувь хүрч буурах эрсдэлтэй байна.

САНХҮҮГИЙН САЛБАР

43. Төсвийн зарлага тэлэлт болон зээл олголт нэмэгдсэний нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 41.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар өслөө. Үүнээс, төгрөгийн хадгаламж 16.7 нэгж хувь, төгрөгийн харилцах 10.5 нэгж хувь, гадаад валютын харилцах 5.8 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.7 нэгж хувиар тус тус өссөн бол валютын хадгаламж 1.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Төсвийн зарлага тэлэлт, зээл олголтын өсөлт, гадаад цэвэр активын өсөлт, мөнгөний бодлогын хүүгийн бууралт зэрэг нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөллөө.

44. Зээлийн үлдэгдлийн өсөлтөд үл хөдлөх хөрөнгө, худалдаа, уул уурхайн салбарын зээл болон цалин, тэтгэврийн зээлийн өсөлт голлон нөлөөллөө. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар улиралд 33.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 31.2 нэгж хувиар өссөн байна. Үүнээс, нийт зээлийн үлдэгдэлд аж ахуйн нэгж

байгууллагын зээл 13.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар өссөн байна. Тодруулбал, аж ахуйн нэгж байгууллагын салбараар ангилсан зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул уурхай, олборлолт 44.2 хувиар өсөж 1.9 их наяд төгрөг, худалдааны салбар 13.2 хувиар өсөж 4.1 их наяд төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 19.1 хувиар өсөж 2.1 их наяд төгрөг, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 37.3 хувиар өсөж 0.7 их наяд төгрөг болж нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Харин иргэдийн зээлийн үлдэгдэл 19.5 наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.8 хувиар өссөн байна. Өсөлтөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн цалин тэтгэврийн зээл 50.5 хувиар өсөж 6.9 их наяд төгрөг, ипотек болон үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 50.8 хувиар өсөж 4.9 их наяд төгрөг, бөөний болон жижиглэнгийн худалдаа 26.7 хувиар өсөж 2.1 их наяд төгрөг, өрхийн хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээл 25.6 хувиар өсөж 1.8 их наяд төгрөг болж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд



45. Иргэд болон аж ахуйн нэгж байгууллагад шинээр олгосон зээл өсөлттэй хэвээр байна. Шинээр олгосон зээлийн хэмжээ 2024 оны 2 дугаар улиралд 16.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 52.4 хувиар буюу 5.6 их наяд төгрөгөөр өссөн байна. Тус өсөлтөд ААНБ-д олгогдсон зээл 30.1 нэгж хувийг, иргэдийн зээл 22.3 нэгж хувийг тус тус эзэлж байна. Уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга болон боловсруулах салбарт шинээр олгосон зээл нэмэгдсэн нөлөөгөөр ААНБ-д шинээр олгосон зээлийн хэмжээ 7.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 55.8 хувиар өссөн байна. Иргэдэд шинээр олгосон зээлд цалин тэтгэврийн зээл, өрхийн хэрэглээ хадгаламж барьцаалсан зээл, ипотек, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд олгосон зээл өссөн нь голлох нөлөө үзүүлснээр өмнөх оны мөн үеэс 39.1 хувиар иргэдийн зээл олголт нэмэгдэж, 8.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Банкнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч, 15.9 хувьд хүрэхэд ХАА салбар, боловсруулах салбарын зээлийн хүүгийн бууралт эерэг нөлөө үзүүлээ.


46. Зээлийн эргэн төлөлт сайжирч, чанаргүй зээлийн харьцаа найман жилийн доод түвшинд хүрлээ. Банкны салбарын зээлийн эргэн төлөлт 3.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар өсөж, зээл олгох эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна. Нийт төлөгдсөн зээлийн өсөлтийн 21.7 нэгж хувийг ААНБ, 16.0 нэгж хувийг иргэдийн зээлийн төлөлт бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2024 оны 2 дугаар улиралд 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 нэгж хувиар буурсан байна. Энэ нь нийт зээлийн үлдэгдлийн 5.9 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн найман жилийн доод түвшинд хүрсэн байна. Тайлант хугацаанд иргэдийн чанаргүй зээлийн иргэдэд олгогдсон нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хэмжээ 2.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна. Нийт аж

ахуйн нэгж, байгууллагын чанаргүй зээлийн ААНБ-ын зээлийн үлдэгдэлд эзлэх хэмжээ 10.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувиар буурсан байна.


47. Өрхийн бодит орлого нэмэгдэж, иргэд болон байгууллагын төгрөгийн хадгаламж өсөлттэй байлаа. Банкнуудын хадгаламжийн жилийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 24.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өслөө. Үүнээс, иргэдийн хадгаламж 20.0 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өссөн байна. Иргэдийн хадгаламжийн өсөлтөд төгрөгийн хадгаламж 25.4 нэгж хувийг, гадаад валютын хадгаламж -2.9 нэгж хувийг бүрдүүлсэн байна. ААНБ-ын хадгаламж 4.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өссөн байна. Байгууллагын хадгаламжийн өсөлтөд төгрөгийн хадгаламж 35.9 нэгж хувийг, валютын хадгаламж -5.5 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Эдийн засаг тэлэлттэй үед банкнуудын хадгаламж болон зээлийн үлдэгдэл зэрэг өсөх хандлагатай байдаг. Төгрөгийн ханш чангарсантай холбоотой иргэд болон байгууллагын валютын хадгаламж буурч, төгрөгийн хадгаламж руу шилжсэн байна. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 2 дугаар улиралд 11.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өссөн байна. Банкнуудын хадгаламжийн өсөлтөд өрхийн бодит орлогын өсөлт гол нөлөө үзүүлээ.

48. Мөнгөний бодлогын хүү буурсантай холбоотой банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү буурлаа. Мөнгөний бодлогын хүү буурсантай холбоотой банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 2 дугаар улиралд 11.0 хувь болж, өмнөх улирлаас 1.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурсан байна. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү бууралттай үед хадгаламжийн хүүгийн түвшинд бууралт ажиглагдахгүй байгаа нь арилжааны банкнуудын санхүүжилтийн хэрэгцээ өндөр байгааг харуулж байгаа бөгөөд бодлогын

Зураг 3.5. Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд



Зураг 3.6. Нийт хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн түвшин



хүүгийн өөрчлөлтийн хугацааны хоцрогдлын нөлөөгөөр цаашид хадгаламжийн хүү буурч болзошгүй байна.


49. Бодит үйлчилж буй зээлийн хүүгийн зөрүү бууралттай хэвээр байна. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2024 оны 2 дугаар улиралд 17.2 хувьтай, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.3 хувьтай, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувийн өсөлттэй байна. Бодит үйлчилж буй зээлийн хүүгийн зөрүү 5.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна. Бодит үйлчилж буй зээлийн хүүгийн зөрүү нарийсах нь банкны салбарын өрсөлдөөн өндөр байгааг харуулах бөгөөд харилцагчийг хадгалах, татах замаар татан төвлөрүүлэлтийг ихэсгэх стратегийг банкнууд хэрэгжүүлж байгааг харуулдаг. Бодлогын хүүгийн бууралтын нөлөөгөөр цаашид хүүгийн зөрүү буурах нь зээлийн өсөлтийг дэмжих эдийн засгийн идэвхжилийг сайжруулах нөлөө үзүүлнэ.

50. Банкнуудын ашигт ажиллагаанд иргэд, ААНБ-ын хадгаламж өсөж, хэвийн зээл олголт нэмэгдсэнээр активын чанар сайжирсан нь эерэг нөлөө үзүүлээ. Банкнуудын активын өгөөж 2024 оны 2 дугаар улиралд 2.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар сайжирсан байна. Банкнуудын ашигт ажиллагаа нэмэгдэхэд зээлийн эх үүсвэр болох иргэд, ААНБ-ын хадгаламж өссөн, хэвийн зээл олголт нэмэгдсэнтэй холбоотой хөрөнгийн чанар сайжирсан нь голлох нөлөө үзүүлсэн байна. Арилжааны банкнуудын эрсдэлээр жигнэсэн активд ноогдох ашгийн харьцаа 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.

51. Арилжааны банкнуудын өөрийн хөрөнгө өсөлттэй хэвээр байна. Банкны системийн нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2024 оны 2 дугаар улиралд 6.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өслөө. Өөрийн хөрөнгийн өсөлттэй холбоотой нэгдүгээр зэрэглэлийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн хөрөнгөд харьцуулсан харьцаа 12.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурсан байна. Тус харьцаа нь банкны тухай хуулийн 17 дугаар зүйл болон Монголбанкны А-138 дугаар тушаалаар батлагдсан зохистой харьцааны шалгуурын дагуу 9 хувиас багагүй байх шаардлагатай байдаг. Бууралтад зээл олголт нэмэгдсэнтэй холбоотой эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар өсөж, 45.2 их наяд төгрөгт хүрсэн нь голлох нөлөө үзүүлээ. Өөрийн хөрөнгийн өсөлттэй холбоотой цэвэр нээлттэй позиц, нийт өөрийн хөрөнгийн харьцаа -16.9 хувь болж, абсолют утгаар 2.3 нэгж хувиар буурсан байна.

52. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөлттэй хэвээр байна. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны 2 дугаар улиралд 11.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өслөө. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 16.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд банкнуудын анхдагч зах зээлд хувьцаа арилжаалж эхэлсэнтэй холбоотой сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх сайжирч байна. Тайлант хугацаанд үнэт цаасны арилжааны нийт хэмжээ 645.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 дахин нэмэгдсэн бөгөөд арилжааг төрлөөр нь харвал 80.9 хувийг компанийн бондын арилжаа, 8.9 хувийг хувьцааны арилжаа, 6.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 3.3 хувийг

Зураг 3.7. Арилжааны банкнуудын ашигт ажиллагаа ба зохистой харьцааны үзүүлэлт



хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлсэн байна.

53. Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, анхдагч зах зээлийн өрийн хэрэгслийн арилжаа өсөлттэй байлаа. Хөрөнгийн зах зээл дээр 2024 оны 2 улиралд нийт 63 удаагийн арилжаагаар 57.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны арилжаа хийгдсэн 15.2 тэрбум төгрөгийг буюу 26.7 хувийг анхдагч зах зээлийн арилжаа, 41.9 тэрбум төгрөг буюу 73.3 хувийг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна. Анхдагч зах зээлийн хувьцааны арилжаа өмнөх

улиралтай харьцуулахад 1.7 дахин өсөж, хоёрдогч зах зээлийн арилжаа 64.7 хувиар буурсан байна. Мөн компанийн өрийн хэрэгслийн нийт арилжаагаар 522.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн байна. Анхдагч зах зээлийн бондын арилжааны дүн нийт 520.0 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлийн бондын арилжаа 2.5 тэрбум төгрөг байна. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.3 хувиар өссөн байна. Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварын харьцаа 1.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар сайжирсан байна

Зураг 3.8. Хөрөнгийн зах зээл



БҮЛЭГ 4

ГАДААД СЕКТОР

- 4.1 ГАДААД ХУДАЛДАА
- 4.2 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
- 4.3 ГАДААД ӨР

4. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Экспортын орлого 2024 оны эхний хагас жилд өнгөрсөн оны мөн үеэс 4 орчим хувиар өсөж, өмнөх улирлын өсөлтийн хурдыг давлаа. Үүнд, чулуун нүүрс, төмрийн хүдрийн биет хэмжээ нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнэ өссөн нь эерэг нөлөө үзүүлээ. Оны сүүлийн хагас жилд нүүрс, зэсийн баяжмалын биет хэмжээний өсөлт, дэлхийн зах зээл дэх цэвэр зэс, алтны өндөр үнэ нь экспортын өсөлтийг дэмжихээр байна. Уул уурхайн экспортын үйл ажиллагааны идэвхжилийн нөлөөгөөр тоног төхөөрөмж, том машин механизмын импорт нэмэгдсэний зэрэгцээ зээл олголт эрчимжиж, өрхийн орлого сайжирснаар нийт импортын дүн өмнөх оны мөн үеэс 26 хувиар өслөө. Импортын өсөлт болон Төв банкнаас своп хэлцлийн хагас дүнг эргэн төлсөнтэй холбоотойгоор төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч, өмнөх улиралтай харьцуулахад гадаад валютын нөөц буурч, төгрөгийн ханш суларлаа.

ГАДААД ХУДАЛДАА

54. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеэс буурлаа. Худалдааны тэнцэл 2024 оны эхний хагас жилд 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеэс 800 сая ам.доллараар буурлаа. Энэ нь импорт 26 хувиар, экспорт 4 хувиар өссөнөөс шалтгаалжээ. Харин худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 11 хувиар буюу 1.4 тэрбум ам.доллараар өсөв (Зураг 4.1).


55. Голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн нь нийт экспортын орлогыг өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. 2024 оны эхний хагас жил экспорт 7.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4 орчим хувиар өслөө. Өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Цаашид, нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өсөлт, дэлхийн зах зээл дэх цэвэр зэс, алтны өндөр үнэ зэрэг нь экспортын орлогын өсөлтийг дэмжихээр байна.

56. Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ буурлаа. 2024 оны эхний хагас жил нүүрсний экспортын биет хэмжээ 40.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн ч хилийн үнэ 28 хувиар буурлаа. Үүнд, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сэргэж чадахгүй байгаагаас шалтгаалан Ганцмод боомт дэх коксжих нүүрсний үнэ буурсан нь голлон нөлөөлжээ. Цаашид, нүүрсний биет хэмжээний өсөлт хадгалагдах хэдий ч хилийн үнэ нэмэгдэх төлөвгүй байна.

57. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж дэх арилжааны идэвх суларч байна. 2024 оны эхний хагас жилд уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 14.5 сая тонн нүүрсийг тонн тутмыг нь 119 ам.доллараар, 980 мянган тонн төмрийн хүдрийг тонн тутмыг нь 73 ам.доллараар тус тус арилжаалаад байна. БНХАУ-ын үл хөдлөх салбарын хямрал болон тус улсын арматурын үйлдвэрлэлийн талаарх шинэ журам энэ оны 9 дүгээр сард хэрэгжих болсноор нүүрс, төмрийн хүдрийн эрэлтийг гол тодорхойлогч ган хайлуулах салбарт тогтворгүй байдлыг богино хугацаанд


Зураг 4.1. Гадаад худалдааны үзүүлэлт

1. Гадаад худалдааны бараа эргэлт, тэнцэл (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

2. Экспортын жилийн өсөлт (өсөлтийн хувь)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

3. Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ

Бүтээгдэхүүний нэр	2023.06	2024.06	Өсөлт
Зэсийн баяжмал /мян.тонн/	764	785	2.7 %
Нүүрс /сая.тонн/	29.5 4	0.6	27.3 %
Алт /кг/	5,398	5,048	-6.9 %
Төмрийн хүдэр /мян.тонн/	2,681	3,596	25.4 %
Газрын тос /мян. баррель/	2,356	2,056	-14.3 %

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

бий болгоод байна. Шинэ журмын гол өөрчлөлт нь арматур хайлуулах болон туршилт хийх аргыг илүү нарийвчлан шинэ стандарттай болгож батлахаар байгаа нь ган хайлуулах зардлыг нэмэгдүүлэхээр байна. Үүнээс шалтгаалан, уул уурхайн бүтээгдэхүүний бирж дэх амжилттай болсон арилжааны тоо энэ 6 дугаар сард суларч, нүүрс төмрийн хүдрийн хэлцлийн үнэ буурлаа.

58. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспорт нэмэгдлээ. 2023 оны 3 дугаар сард Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор тус компанийн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдсэнээр 2024 оны эхний хагас жил зэсийн баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө. Түүнчлэн, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 3,569 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн байна. Цаашид, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ өсөхөөр байна.


59. Газрын тосны экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа. Газрын тосны олборлолт удааширнаар газрын тосны экспорт 2,065 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 14 хувиар буурлаа. Цаашид, газрын тосны экспортын биет хэмжээний өсөлт нэмэгдэх төлөвгүй байна.

60. Зудын нөхцөл байдлаас шалтгаалан уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурлаа. Үүнд, нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 57 хувиар, ноосны экспорт 45 хувиар, арьс ширний экспорт 31 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөллөө.

61. Эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалагдаж, бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээг өсгөлөө. Үндэсний статистикийн хорооноос заралдаг салбар хоорондын тэнцлийн статистикт нийт импортыг үйлдвэрлэлийн завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлал гэж гурав хуваан ангилдаг. Нийт импортын 60 орчим хувь нь үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагддаг бөгөөд эдийн засаг 9 улирал дараалан тогтмол өссөнөөр 2024 оны эхний хагас жилийн байдлаар импорт 5.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар өслөө (Зураг 4.3).


Зураг 4.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны тоо (тэрбум ам.доллар)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж.

2. Нүүрсний дундаж үнэ (ам доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

3. Төмрийн хүдэр, баяжмалын дундаж үнэ (ам доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

62. Худалдааны түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт бага түвшинд байв.


Импортын дүн өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллараар өссөний 90 орчим хувийг тоо хэмжээ, 10 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна (Зураг 4.3). Манай улсын нийт импортын 40 хувийг БНХАУ-аас, 26 хувийг ОХУ-аас, 10 хувийг Япон улсаас худалдан авч байна. БНХАУ-аас машин, механик, тоног төхөөрөмж, хүнс, хэрэглээний бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэж байгаа бөгөөд тус улсын инфляц хоёрдугаар улирлын байдлаар 0.2 хувь байсан. Мөн Япон улсаас автомашин, түүний сэлбэг худалдан авч байгаа бөгөөд Япон иений ам.доллартой харьцах ханш 1990 оноос хойших түүхэн доод түвшинд хүрч буурснаар тус улсаас худалдан авч буй барааны зардлыг бууруулж байна. Харин ОХУ-ын инфляц хоёрдугаар улирлын байдлаар 7.8 хувь байна. Гэсэн хэдий ч тус улсаас худалдан авч буй бүтээгдэхүүний 70 хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба ОХУ-ын Роснефть компанитай 2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө.

63. Импортын 25.9 хувийн жилийн өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт өсөлтийн 12.6 нэгж хувийг машин механик, тоног төхөөрөмж, 7.9 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 5.4 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна (Зураг 4.3).

64. Эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр сайжирснаар тоног төхөөрөмжийн импорт өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсөж 1.0 тэрбум ам.долларт хүрлээ. Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай зарим тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлснөөр тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг дэмжихээр байна. Мөн уул уурхай болон тээврийн салбарын идэвхжилтэй холбоотойгоор ачааны тээврийн хэрэгслийн импорт 337 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 51 хувиар, экскаватор, шанагат ачигчийн импорт 184 сая ам.долларт хүрч 2 дахин, дизелийн түлшний импорт 24 хувиар тус тус өслөө.


Зураг 4.3. Импорт

1. Импортын жилийн өсөлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2. Импортын өөрчлөлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

65. Өрхийн орлогын өсөлт нь хүнсний бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлж байна.

Өрхийн бодит орлого сүүлийн дөрвөн улирал дараалан өндөр өсөж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр хүнсний бүтээгдэхүүний импорт 517 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өслөө. Мөн гурилын үнийн өсөлтийг бууруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд улаанбуудайн гурилын импортод хязгаар тогтоохгүй байж, 2024 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс гаалийн албан татвараас чөлөөлсөн. Ингэснээр гурилын импорт 31.9 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 13 дахин нэмэгдлээ.

66. Зээл олголт нэмэгдэж, иргэдийн худалдан авах чадвар нэмэгдсэнээр удаан эдэлгээтэй хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт нэмэгдлээ. Энэ оны эхний улиралд иргэдийн зээл олголт 36.0 хувиар өссөнөөр удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэв. Түүнчлэн, Японы иений ханш суларсны нөлөөгөөр манай улсын суудлын автомашины импортын хилийн дундаж үнэ 20.0 орчим хувиар буурснаар суудлын автомашины импортын тоо хэмжээ 2024 оны эхний хагас жилийн байдлаар 57 мянган ширхэгт хүрч, 76 хувиар өслөө. Суудлын авто машины импортын өсөлт болон аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээг олноор тохиож, авто бензиний импорт 167 сая ам.долларт хүрч, 46 хувиар өслөө.

67. Ипотекийн зээлийн эх үүсвэр нэмэгдэж, цементийн гаалийн албан татварыг бууруулснаар барилгын материалын импорт өслөө. Барилгын салбарын үйлдвэрлэл энэ оны эхний хагас жилд 19.5 хувиар өсөж, барилгын материалын импорт 599 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 18 хувиар өслөө. Хуримтлалын сангаас 500 тэрбум төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт оруулж, ипотекийн зээл олголт 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 74.2 хувиар өссөнөөр орон сууцны эрэлт өсөж, барилгын материалын импортыг нэмэгдүүллээ.

Барилгын үнийн хөөргөдлөөс сэргийлэх хүрээнд цементийн импортод хугацаа, хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, Засгийн газрын 2024 оны 188 дугаар тогтоолоор цементийн гаалийн албан татварыг 20 хувь байсныг 5 хувь болгож бууруулснаар цементийн импорт 86 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна. Цементийн гаалийн албан татварын хөнгөлөлт энэ оны 10 сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх боловч 2024 оны төсвийн тодотголд тусгагдсан томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр оны сүүлийн саруудад барилгын материалын импорт нэмэгдэхээр байна

68. Импортын өсөлт оны сүүлийн саруудад хадгалагдахаар байна. Монгол улсын нийт импортын 80 орчим хувь нь Тяньжин боомтоор дамжин, төмөр замаар тээвэрлэгдэн Замын-Үүд боомтоор орж ирдэг. 2024 оны 3 дугаар сарын сүүлээс эхлэн Тяньжин боомтоос гарах галт тэрэгний тоо буурснаар энгийн үед 3,000 орчим байдаг чингэлгийн тоо 6,000 орчим хүрсэн. Гэсэн хэдий ч импортын өсөлт өндөр байлаа. Тяньжин боомтоос гарах галт тэрэгний тоо нэмэгдэж, 2024 6 дугаар сарын байдлаар чингэлгийн тоо 5,000 орчим болж буураад байна. Цаашид тээвэрлэлт эрчимжсэнээр оны сүүлийн саруудад хуримтлагдаад буй чингэлгийн нөлөөгөөр импортын өсөлт хадгалагдахаар байна.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ


69. Урсгал данс алдагдалтай гарахад барааны импорт өсөж, хөрөнгө оруулалтын ногдол ашиг, хүүгийн төлбөр нэмэгдсэн нь нөлөөллөө. Урсгал данс 2024 оны эхний хагас жилд 0.6 тэрбум ам.долларын алдагдалтай гарснаар төлбөрийн тэнцлийн алдагдал 57 сая ам.долларт хүрлээ. Урсгал дансны алдагдал нэмэгдэхэд барааны импорт өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллаар, шууд хөрөнгө оруулалтын ногдол ашиг болон зээлийн хүүгийн төлбөр өмнөх оны мөн үеэс 0.3 тэрбум ам.доллаар тус тус өссөн нь голлон нөлөөллөө. Харин тээврийн салбарын идэвхжил өндөр байсан ч ачаа тээврийн үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс буурснаар нийт үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хадгалагдлаа (Зураг 4.4).

70. Төв банкны своп хэлцлийн эргэн төлөлтэй холбоотой гарах урсгал өссөн ч шууд хөрөнгө оруулалт болон бондын орох урсгал нэмэгдсэнээр санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ. Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юань буюу 0.6 тэрбум ам.долларын эргэн төлөлтийг хийсэн нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүллээ. Ингэснээр тус своп хэлцлийн үлдэгдэл 6.0 тэрбум юань буюу 0.8 тэрбум ам.доллар болж буурлаа. Харин шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум ам.доллаар нэмэгдэж, "МИК ОССК", Монгол Улсын Хөгжлийн Банк, Голомт банк зэрэг байгууллагууд олон улсын зах зээлд шинээр бондууд гаргаснаар 2024 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум ам.доллаар нэмэгдлээ.

71. Өмнөх улиралтай харьцуулахад гадаад валютын нөөц буурч, төгрөгийн ханш суларлаа. Монголбанк своп хэлцлийн эргэн төлөлтийг хийсэнтэй холбоотойгоор гадаад валютын нөөц 2024 оны 2 дугаар улирлын эцэст 4.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх улирлын эцэсээс 0.4 тэрбум ам.доллаар буурлаа. Энэ нь бараа, үйлчилгээний импортын 3.9 сарын хэрэгцээг хангах түвшинтэй тэнцэж байна.

Зураг 4.4. Төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш

1. Урсгал данс
(сая ам.доллар)



2. Санхүүгийн данс
(сая ам.доллар)



3. Төгрөгийн ханшийн жилийн өөрчлөлт
(хувь)



Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 2 дугаар улирлын эцэст 3,381 төгрөг болж, өмнөх улирлын эцсээс 5.1 төгрөгөөр буюу 0.1 хувиар суларлаа. Харин бодит ханшийн индекс 2024 оны эхний улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар чангараад байсан бол 2 дугаар улирлын эцсийн байдлаар 5.8 хувиар чангарсан байна.

72. Хөрөнгө оруулалт нэмэгдэж, хадгаламжийн өсөлт саарснаар урсгал дансны тэнцэл буурлаа.

Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Цар тахлын үе буюу 2020-2021 онд урсгал дансны тэнцэл сайжирч, алдагдал буурсан нь эдийн засгийн идэвхжил саарч, нийт хөрөнгө оруулалт буурсантай холбоотой байв. Харин 2023 онд төсвийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор Засгийн газрын хадгаламж өсөхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын өсөлт өмнөх оноос саарснаар урсгал дансны тэнцэл сайжирсан. Гэсэн хэдий ч 2024 онд Засгийн газрын хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хадгаламжийн өсөлт саарснаар урсгал дансны тэнцэл муудаж байна (Зураг 4.5).

73. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна.


Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг. Манай улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны эхний хагас жилийн байдлаар -41.6 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий -185 хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсад байршиж буй, гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 50.6 тэрбум ам.доллар байгаа бол гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө 9.0 тэрбум ам.доллар байна. Цаашид урсгал дансны алдагдлыг бууруулж, гадаад валютын нөөцийг зузаатгах замаар гадаад хөрөнгө оруулалтын позицыг сайжруулж, гадаад шокт өртөх эмзэг байдлыг бууруулах шаардлагатай.

74. Төсвийн зарлагын өсөлт импортыг нэмэгдүүлж, урсгал дансны тэнцлийг муутгаж болзошгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын огцом өсөлт нь импортыг өсгөх замаар урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд үзүүлэх дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Тухайлбал, ирэх онуудад импорт жилд дунджаар 1.8 тэрбум ам.доллароор өсөж, Засгийн газрын гадаад зээлийн хүү болон үндсэн төлбөрт жилд дунджаар 0.5 тэрбум ам.доллар төлөхөөр байна.


Зураг 4.5. Урсгал дансны тэнцэл ба гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц

1. Урсгал дансны тэнцлийн жилийн өөрчлөлт (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк
Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын гүйсэн нийлбэрээр тооцов.
Хөрөнгө оруулалтын өсөлт (бууралт) урсгал дансны тэнцлийг бууруулна (нэмэгдүүлнэ).

2. Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц (ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

75. Нийт гадаад өрийн үлдэгдлийн дүн өссөн ч ДНБ-д эзлэх хувь буурлаа. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн эцэст 34.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум ам.доллаароор буюу 5.4 хувиар өслөө. Гэсэн хэдий ч ДНБ-ий өсөлттэй холбоотойгоор ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 155 хувь болж, өмнөх оны мөн үеэс 26 нэгж хувиар буурсан байна (Зураг 4.6).

76. Төв банк болон Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл буурсан ч хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өслөө. Төв банк Хятадын Ардын Банк хооронд байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор Монголбанкны гадаад өр өмнөх оны мөн үеэс 869 сая ам.доллаароор буюу 47 хувиар буурсан бол зээлийн ашиглалт өссөнтэй холбоотойгоор Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос ердөө 26 сая ам.доллаароор буурсан байна. Харин хувийн хэвшлийн гадаад өр өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум ам.доллаароор буюу 11 хувиар өссөн нь Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл өсөхөд голлон нөлөөллөө (Зураг 4.6). Тухайлбал, шууд хөрөнгө оруулалттай компанийн зээллэг өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум ам.доллаароор, банкны салбарын гадаад өр өмнөх оны үеэс 140 сая ам.доллаароор тус тус өссөн байна.

77. Нийт гадаад өрийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн өр бүрдүүлж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 22 хувийг Засгийн газрын өр, 5 хувийг төв банкны өр, үлдсэн 75 хувийг хувийн хэвшлийн өр тус тус бүрдүүлж байна. Хувийн хэвшлийн гадаад өрийн дийлэнх буюу 77 хувийг уул уурхайн салбар, 10 хувийг санхүүгийн салбар, 4 хувийг худалдааны салбар, үлдсэн 9 хувийг бусад 18 салбарын өр бүрдүүлж байна.

78. Гадаад өрийн динамик дунд хугацаанд харьцангуй тогтвортой байгаа ч ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөллөөр экспорт болон ДНБ-ий өсөлтийн эерэг нөлөөгөөр ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ



дунд хугацаанд тогтвортой буурахаар байна. Гэсэн хэдий ч ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад гадаад өр болон ДНБ-ий харьцаа урсгал дансны тэнцэл 1 стандарт хазайлтаар буурахад 11.9 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 13.7 нэгж хувиар тус тус өсөхөөр байна (Зураг 4.7)

БҮЛЭГ 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 5.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
- 5.2 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА
- 5.3 ОЛОН УЛСАД 2024 ОНД ЗАРЛАГДСАН ИНДЕКСҮҮД

5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ


Дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын идэвхжил хадгалагдаж байгаа бол хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байна. Томоохон улсуудад инфляцын түвшин буурах хандлага ажиглагдаж, бодлогын хүү буурах хүлээлтийг нэмэгдүүлж байна. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд саарч, 2024 оны өсөлт тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрэхгүй байх магадлалтай байна. Үүнээс шалтгаалан дэлхийн зах зээл дэх нүүрс болон төмөр хүдрийн үнэ буурлаа.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

79. Дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын идэвхжил хадгалагдаж байгаа бол хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байна. Эдийн засгийн богино хугацааны төлөвийг илэрхийлэх дэлхийн худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) хөгжингүй болон хөгжиж буй орнуудад үйлчилгээний салбарын идэвхжил хадгалагдаж байгааг, харин хөгжингүй орнуудын хувьд аж үйлдвэрлэлийн салбар сэргээгүй байгааг харуулж байна. Тухайлбал, хөгжингүй орнуудын аж үйлдвэрлэлийн PMI индекс 2022 оны 10 дугаар сараас хойш тэлэлтийг илэрхийлэх босго утга 50-аас бага хэвээр байна (Зураг 5.1).

80. АНУ бодлогын хүүгээ бууруулах хүлээлт нэмэгдэж байна. АНУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 3.0 хувьд хүрч эрчимжиж, инфляц 2024 оны 7 дугаар сард 2.9 хувь буюу 2021 оны 3 дугаар сараас хойших хамгийн бага түвшинд хүрлээ. Инфляц зорилтот түвшин рүү ойртож байгаатай холбоотойгоор Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүгээ 2024 оны 9 дүгээр сард бууруулах хүлээлт зах зээлд нэмэгдээд байна.

81. Евро бүсийн эдийн засгийн өсөлт хадгалагдав. Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх улиралтай ижил түвшинд буюу 0.3 хувьд хадгалагдаж, инфляц 2024 оны 7 дугаар сард 2.6 хувьд хүрч зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Гэсэн хэдий ч бүсийн хамгийн том эдийн засаг болох ХБНГУ-ын эдийн засаг хөрөнгө оруулалтын бууралтын нөлөөгөөр 0.1 хувиар агшаад байна. Цаашид инфляц үргэлжлэн буурснаар Европын төв банк бодлогын хүүг энэ онд дахин бууруулж магадгүй байна.



82. Япон улсын эдийн засгийн өсөлт эрчимжив. Энэ оны эхний улиралд 0.6 хувиар агшсан Япон улсын эдийн засаг 2024 оны 2 дугаар улиралд 0.8 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд цалингийн өсөлт өрхийн орлого болон хувийн хэрэглээг дэмжсэн нь голлон нөлөөллөө. Харин инфляц 2024 оны 7 дугаар сарын байдлаар 2.8 хувь буюу зорилтот түвшнээс өндөр байгаа нь энэ онд хасах хүүгийн бодлогоо халж, мөнгөний бодлогын төлөвөө өөрчилсөн тус улсын төв банк бодлогын хүүгээ дахин өсгөх магадлалыг нэмэгдүүлж байна.

83. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарав. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.7 хувьд хүрч, өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар саарлаа. Тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлтийн сэргэлт сул байсан нь эдийн засгийн өсөлт саарахад нөлөөллөө. Улмаар 2024 оны эхний хагас жилийн өсөлт 5.0 хувьд хүрсэн бөгөөд оны сүүлийн хагаст эдийн засгийн үйл ажиллагаа үргэлжлэн саарсан тохиолдолд 2024 оны өсөлт засгийн газрын зорилтот түвшин 5.0 хувиас бага байх эрсдэлтэй байна. Тус улсын бодлого боловсруулагчид эдийн засгийг дэмжих хүрээнд засгийн газрын урт хугацаат тусгай бонд болон орон нутгийн тусгай бонд гаргах ажлыг эрчимжүүлж, бодлогын хүүг бууруулах зэрэг төсөв, мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлж байна.

84. ОХУ-ын эдийн засгийн өсөлт саарч, бодлогын хүүг хэвээр хадгалав. ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.0 хувь болж, өмнөх улирлаас 1.4 нэгж хувиар буурлаа. Экспорт 2024 оны

2 дугаар улиралд өмнөх улирлаас 3.9 хувь, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар тус тус өслөө. Экспортын өсөлтийг газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна. Импорт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурсан байна. Импортын бууралтад рублийн ханш суларч, логистикийн хүндрэл үүссэн нөхцөл байдал гол нөлөөлөл үзүүллээ. Инфляцын түвшин 2024 оны 2 дугаар улиралд 8.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувийн өсөлттэй байна. Инфляцын түвшин 2023 оны 2 дугаар сараас хойш өсөж, төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байгаа хэдий ч тус улсын Төв банк бодлогын хүүг 16 хувьд хэвээр хадгалсаар байна. Украинд хийж буй довтолгоотой холбоотой тус улсын төсөв сүүлийн 3 жилийн хугацаанд өндөр тэлэлтэй байгаа тул цаашид инфляцыг тогтвортой түвшинд барих, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд мөнгөний зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь чухал байгаа талаар олон улсын эдийн засагчид дүгнэжээ.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

85. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 9,094 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өссөн байна. Дэлхийн томоохон зэсийн ил уурхайнуудын нэг болох Чили улсын “Кобре Панам” хаагдсан, зэсийн олон уурхайтай үндэстэн дамнасан “Англо Американ” компани зардлаа танаж, зэсийн үйлдвэрлэлээ бууруулахаа мэдэгдсэн нь богино хугацаанд нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөлж байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн эрэлт дунд хугацаанд нэмэгдэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2024 онд 9,500 ам.долларт хүрэхээр байна.

86. Сингапурын бирж дээрх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 278 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 19 хувиар буурсан байна. Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж, нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх салбар сэргэж чадахгүй байгаа нь эрэлтийг бууруулахаар байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 250 ам.долларт хүрэхээр байна.

87. Алтны 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 2,206 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өслөө. Геополитикийн хурцадмал байдал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж


байгаа нь алтны эрэлт болон үнэ өсөхөд нөлөөлж байна. Дэлхийн банкны үзэж байгаагаар дунд хугацаанд дэлхийн эдийн засаг тогтворжиж, алтны эрэлт бага зэрэг сулрах хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2024 онд 2,200 ам.долларт хүрэхээр байна.

88. Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 118 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 15 хувиар буурсан байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа, Австрали улс шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил бүр 6 хувиар нэмэгдүүлэхээ зарласан нь үнэ буурахад голлон нөлөөллөө. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2024 онд 120 ам.долларт хүрэхээр байна.


89. Брент төрлийн газрын тосны 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 82 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 6 хувиар өслөө. ОПЕК-ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулахаар шийдвэрлэснээс гадна нефть, газрын тосны олборлолтын 35 орчим хувийг бүрдүүлдэг Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож, үнэ өсөж байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Энэтхэг улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 85 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ


1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл, шинжээчдийн төсөөлөл (\$/тонн)




2. Цэвэр зэсийн үнийн 2024 оны төсөөллийн хөдөлгөөн (\$/тонн)




3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл, шинжээчдийн төсөөлөл (\$/тонн)




4. Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнийн 2024 оны төсөөллийн хөдөлгөөн (\$/тонн)




5. Лондоны металлын бирж дэх алтны гүйцэтгэл, шинжээчдийн төсөөлөл (\$/тонн)




6. Алтны үнийн 2024 оны төсөөллийн хөдөлгөөн (\$/тонн)




7. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл, шинжээчдийн таамаглал (\$/тонн)




8. 62 хувийн агууламжтай төмрийн хүдрийн үнийн 2024 оны төсөөллийн хөдөлгөөн (\$/тонн)



9. Brent газрын тосны гүйцэтгэл, шинжээчдийн төсөөлөл (\$/баррель)



10. Brent газрын тосны үнийн 2024 оны төсөөллийн хөдөлгөөн (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: 2019-2023 оны дундаж үнийн түвшин цэгтэй ногоон зураасаар, ялгаатай байгууллага бүрийн 2024 оны дундаж үнийн төсөөллийн бусад өнгөөр дүрслэв.

Тэмдэглэл: Голын хар зураас нь тухайн хугацаанд хийгдсэн төсөөллүүдийн дундаж юм. Зураг дээрх бусад өнгийн зураас нь шинжээчдийн зарласан 2024 оны дундаж үнийн төсөөлөл болно. Жишээлбэл, Алтны 2024 оны үнийн төсөөллийг энэ оны 1 сараас эхлэн шинжээчид тасралтгүй өсгөж байгааг голын хар зурааснаас харж болно.

ОЛОН УЛСАД 2024 ОНД ЗАРЛАГДСАН ИНДЕКСҮҮД

90. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертельсманны шилжилтийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс шинэчлэгдэн зарлагдаад байна.

Манай улс эдгээр индексүүдэд авсан үнэлгээг өмнөх үнэлгээтэй харьцуулахад эдийн засгийн үзүүлэлтүүдээр сайжирсан бол засаглалын үзүүлэлтүүдээр үнэлгээ буурсан байна. Тухайлбал уул уурхайн салбарын өсөлтийг дагаж эдийн засгийн гүйцэтгэл сайжирсан, төсвийн алдагдал буурч, өрийн хэмжээ багассанаар төсвийн тогтвортой байдал сайжирсан нь индексүүдийн үнэлгээг ахиуллаа. Харин авлига, хээл хахууль өндөр, бодлогын үр дүнтэй хэрэгжилт хангалтгүй, зохицуулалт оновчгүй байгаа зэргээс засаглалын үнэлгээг бууруулсан байна. Дэлгэрэнгүйг индекс тус бүрээр дараах хэсгээс уншина уу.

91. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан: Дотоодын эдийн засаг сайжирсан нь Монгол Улсын өрсөлдөх чадварт эергээр нөлөөллөө.

Монгол Улс 2024 онд Дэлхийн өрсөлдөх чадварын индексээр¹⁰ 46.3 оноогоор 67 улсаас 61 дүгээрт жагсаж, 1 байр ахилаа.

Хүснэгт 6. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2023		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Эдийн засгийн чадамж	37.6	#60	47.2▲	#42▲
Засаглалын үр ашиг	28.3	#58	35.0▲	#53▲
Бизнесийн үр ашиг	10.3	#64	20.3▲	#62▲
Дэд бүтэц	6.5	#63	14.4▲	#64▼
Нэгдсэн индекс	35.6	#62	46.3▲	#61▲

¹⁰ Дэлхийн өрсөлдөх чадварын төв (IMD)-өөс жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан нь аж ахуйн нэгжүүдэд нээлттэй өрсөлдөх орчныг бүрдүүлсэн байдлыг хэмждэг. Тус индексийг Эдийн засгийн гүйцэтгэл, Засаглалын үр ашиг, Бизнесийн үр ашиг, Дэд бүтэц гэсэн 4 бүлгийн 336 үзүүлэлтийг хамруулж 1-100 хүртэлх онооны хооронд нэгтгэн үнэлдэг. Индекс 100-д ойртох тусам өрсөлдөх чадвар өндөр, 0-д ойртох тусам өрсөлдөх чадвар сул байна гэж үздэг. Үнэлгээний 2/3-ыг статистик мэдээлэл, үлдсэн хэсгийг удирдах албан тушаалтнуудын санал асуулгад тулгуурлан тооцдог.

Дэд үзүүлэлтүүдээр задлан харвал дотоодын эдийн засаг 31 байр, төрийн санхүү 16 байр, олон улсын худалдаа 10 байр ахиж өндөр өсөлт үзүүлжээ. Энэ өсөлтөд эдийн засаг сайжирсан, төсвийн тэнцэл ашигтай гарч тогтвортой байдал нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харин шинжлэх ухааны дэд бүтцийн үзүүлэлт 3 байр, эрүүл мэнд ба байгаль орчны үзүүлэлт 2 байр ухарсан байна. Үүнд манай улсын судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулах зардал бага, оюуны өмчийн хамгаалал сул, эрүүл мэндийн салбарын хүртээмж бага байгаа нь нөлөөлсөн байна.

Бусад улсуудын эрэмбийг авч үзвэл 2024 оны тайланд Европын Холбооны орнууд болон Сингапур Улс тэргүүлэгч байр сууриа хадгаллаа. Энэ нь Европын Холбооны улсууд дахь бизнесийг дэмжихэд чиглэсэн институт, засаглал, зохицуулалтын тогтолцоотой холбоотой байна. Түүнчлэн Сингапурт бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн, гадаадын хөрөнгө оруулалт татахад хялбар, ил тод, үр ашигтай зохицуулалттай, олон улсын худалдаа хийхэд хялбар, тээвэр логистик, дэд бүтэц хөгжсөн байдал зэрэг нь өрсөлдөх чадвартай орчныг бүрдүүлсэн байна. Харин Венесуэл, Аргентин, Перу, Нигер улсын эдийн засаг тогтворгүй, экспортоос хараат, инфляц, улсын өрийн түвшин өндөр тул сүүл мушгижээ.

92. Бертельсманны шилжилтийн индекс: Төсвийн тогтвортой байдал, эдийн засгийн гүйцэтгэл сайжирсан нь Бертельсманны шилжилтийн индексийн¹¹ үнэлгээг ахиуллаа.

¹¹ Бертельсманн сан (Bertelsmann Stiftung)-аас тооцоолон гаргадаг шилжилтийн индекс нь хөгжиж буй болон шилжилтийн үеийн улс орнууд нийгмийн өөрчлөлтийг ардчилал, зах зээлийн эдийн засагт хэрхэн чиглүүлж, удирдаж байгааг хоёр жил тутам дүн шинжилгээ хийж, үнэлдэг. Тус индексийн хүрээнд Төлөв байдлын индекс, Засаглалын индекс гэсэн 2 индекс тооцдог бөгөөд Төлөв байдлын индекс нь дотроо Эдийн засаг, Улс төр гэсэн 2 бүлэгтэй, нийт 32 үзүүлэлтээр 1-10 онооны хооронд үнэлж гаргадаг. Засаглалын индексийг мөн 1-10 онооны хооронд 20 үзүүлэлтээр тооцон гаргадаг. Индекс 10-д ойртох тусам шилжилтийн түвшин өндөр, 1-д ойртох тусам шилжилт муу байна гэж үздэг.

Монгол Улс 2024 онд Төлөв байдлын индексээр 137 улсаас 30 дугаарт жагсаж, өмнөх үр дүнгээс 5 байраар урагшилсан бол Засаглалын индексээр 26 дугаарт жагсаж 3 байраар ухарлаа.

Хүснэгт 7. Бертельсманны шилжилтийн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2022		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Төлөв байдлын индекс	6.45	#35	6.55▲	#30▲
Улс төр	7.25	#26	7.25	#25▲
Эдийн засаг	5.64	#62	5.86▲	#49▲
Засаглалын индекс	5.90	#26	5.83▼	#29▼

Оноогоор задлан харвал Төлөв байдлын индексээр 6.6 оноо авсан нь дэлхийн дунджаас 1.3 оноо, бүс нутгийн дунджаас 1.2 оноогоор илүү байгаа бөгөөд 2022 оны үзүүлэлтээс 0.2 оноо нэмэгдээд байгаа ажээ. Тэр дундаа эдийн засгийн шилжилтийн үзүүлэлтээр 49 дүгээрт жагсаж, 13 байраар ахисан байна. Үүнд уул уурхайн салбарын өсөлтийг дагаж эдийн засгийн гүйцэтгэл сайжирсан, төсвийн алдагдал буурч, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ буурсан болон төсвийн тогтвортой байдал сайжирсан нь голчлон нөлөөлжээ. Харин улс төрийн шилжилтийн үнэлгээ өөрчлөгдөөгүй бол Засаглалын индекс 0.7 оноогоор буурсан байна. Үүнд бодлогын үр дүнтэй хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлсөн гэж дүгнэжээ.

Тус индексийг 2 жилийн өмнөх гүйцэтгэлээр үнэлдэг буюу 2024 оны тайланг 2021-2022 оны гүйцэтгэлд суурилж тооцсон гэсэн үг юм. Иймд 2026 онд гарах дараагийн тайланд 2023-2024 оны эдийн засгийн үзүүлэлтүүдийн өсөлт тусгагдаж, Монгол Улсын үнэлгээ сайжирна гэж үзэж байна.

Олон улсын түвшинд авч үзвэл индекс тооцсон улс орнуудын 83 хувьд шилжилтийн түвшин хязгаарлагдмал эсвэл муу үнэлэгдэж байна. Бертельсманны шилжилтийн Төлөв байдлын индексийн дэлхийн дундаж оноо жилээс жилд буурч байгаа бөгөөд анх 2006 онд тооцож эхэлснээс хойш энэ онд хамгийн доод түвшиндээ хүрч 5.3 оноо, Засаглалын индексээр хамгийн сул буюу 4.6 оноотой үнэлэгдэж байна. Бүлгүүдээр харвал Эдийн засгийн шилжилт 5.3 оноо, Улс төрийн шилжилт 5.2 оноогоор үнэлэгдсэн байна. Төлөв байдлын индексээр тэргүүлж буй 10 улсын 6 нь Зүүн Европын улсууд байх төдийгүй Зүүн Европ (7.8 оноо) бүс нутгийн дундаж оноогоор тэргүүлж, тэр

дундаа төрийн тусгаар тогтнол, улс төрийн оролцоо, төсөв, мөнгөний тогтвортой байдал, өмчийн эрх зэрэг үзүүлэлтүүдээр дэлхийд манлайлж байна. Харин Ойрх Дорнод, Хойд Африкийн улс орнууд (4.2 оноо) Бертельсманны шилжилтийн индексээр сүүл мушгисан бол бусад бүс нутгууд дунджаар 4.9-5.3 оноогоор үнэлэгдэж байна.

93. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс: Авлига, хээл хахуулийн түвшин өндөр, төрийн зохицуулалт оновчгүй байгаа нь Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг бууруулахад голчлон нөлөөллөө.

Дэлхийн өв уламжлалын сангаас¹² жил бүр тооцоолон гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2024 онд дэлхийн 176 улсаас 76 дугаарт эрэмбэлэгдэж өмнөх оноос 3 байр ухарлаа.

Хүснэгт 8. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2023		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Хууль дээдлэх ёс	47.2	#85	46.2▼	#87▼
Засгийн газрын хэмжээ	72.2	#75	70.1▼	#73▲
Зохицуулалт үр ашиг	69.3	#59	67.8▼	#61▼
Зах зээлийн нээлттэй байдал	58.1	#92	58.1●	#89▲
Нэгдсэн индекс	61.7	#73	60.6▼	#76▼

Манай улсын хувьд 2024 онд Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр¹³ 60.6 оноо авсан нь дэлхийн дундаж 58.6 онооноос 2 оноогоор илүү байна. Дэд бүлгүүдээр задлан харвал Хөрөнгө оруулалтын эрх чөлөө 9 байр, Санхүүгийн эрх чөлөө, Төсвийн сахилга бат, Худалдааны эрх чөлөө гэсэн дэд бүлгүүд тус тус 4 байр ахижээ. Үүнд уул уурхайн салбарын өсөлтийг дагаж худалдааны эргэлт нэмэгдсэн, эдийн засгийн үзүүлэлтүүд, төсвийн сахилга бат сайжирсан зэрэг нь манай улсын үнэлгээг шууд сайжруулахын зэрэгцээ худалдаа, хөрөнгө оруулалтын эрх чөлөөний үзүүлэлтүүдийн үнэлгээг мөн ахиулсан байна. Нөгөө талаас авлига, хээл хахууль өндөр, төрийн зохицуулалт оновчгүй байгаа нь төрийн зарчимт байдал, мөнгөний эрх чөлөөний үзүүлэлтүүдийн эрэмбийг харгалзан 12, 10 байр бууруулж индексийн үнэлгээ буурахад голчлон нөлөөлсөн байна.

¹² The Heritage Foundation
¹³ Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг улс орнуудын Хууль дээдлэх ёс, Засгийн газрын хэмжээ, Зохицуулалтын үр ашигтай байдал болон Зах зээлийн нээлттэй байдал гэсэн 4 бүлэг, 12 дэд бүлгийн хүрээнд нэгтгэн тооцдог байна. Нийт 0-100 онооны хооронд үнэлдэг бөгөөд индекс 100-д ойртох тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал өндөр, 0-д дөхөх тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал сул гэж үздэг


Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг тооцоходоо 4 бүлгийн 12 дэд бүлэгт ижил жин өгч тооцдог. 12 дэд бүлэг нь мөн цааш шалгуур үзүүлэлтүүдэд задардаг бөгөөд дэд бүлэг бүр харилцан адилгүй шалгуур үзүүлэлтүүдээр хэмжигддэг. Зарим нь зөвхөн ганц тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол зарим нь чанарын олон үзүүлэлтүүдээр хэмжигдэх бөгөөд дахин өөр индексүүдийг ч дотроо агуулсан байх нь бий. Иймд хамгийн бага шалгуур үзүүлэлт бүхий дэд бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгаа гэж тооцвол Засгийн газрын зарлага, Төсвийн алдагдал, Инфляцын түвшин гэсэн 3 үзүүлэлт индексийн үнэлгээний 20 гаруй хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр үзүүлэлтүүдийг сайжруулснаар Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой гэсэн үг юм.

Дээрх 3 үзүүлэлтээс хамгийн өндөр жин эзэлж байгаа Засгийн газрын зарлагын үзүүлэлтийг авч үзье. Энэ үзүүлэлтийг ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын сүүлийн 3 жилийн дунджаар хэмждэг бөгөөд үзүүлэлт бага гарах тусам сайн, өндөр гарах тусам муу гэж үнэлэгддэг. (Зураг 5.3).



Дээрх зургаас харвал Засгийн газрын зарлагын үзүүлэлт сүүлийн 3 жил буюу 2020-2022 он (Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үр дүн нь 2022 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д дараалан өссөн нь индексийн үнэлгээг бууруулж буй нэг үзүүлэлт болж байна. Харин 2023 онд Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувь буурсан тул уг үзүүлэлтийн ирэх жилийн үр дүн сайжрах төлөвтэй байгаа бол дараагийн 2 жил буюу 2024, 2025 онд Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувь 38.5 болон 37.7 хувьд хүрч тус тус нэмэгдэхээр төлөвтэй байгаа учир үзүүлэлтийн үнэлгээ буурч гарахаар харагдаж байна.

Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувиар улсуудыг тэнцүү тооны улс бүхий 10 бүлэг буюу децилд хуваахад манай улс 7 дугаар децилд, нийт улсуудаас сүүл хагаст багтаж байна (Зураг 5.4).



Цаашид үнэлгээг 1 децил буюу 15-20 байраар ахиулахын тулд Засгийн газрын зардлын ДНБ-д эзлэх хэмжээг 35.9 хувиас 30 хувь болгон бууруулах хэрэгтэй болно. Ингэснээр бусад үзүүлэлтүүд болон бусад улсуудын урагшлах хандлага ижил түвшинд хадгалагдана гэж үзвэл зөвхөн Засгийн газрын зарлагын үзүүлэлтээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс дэх манай улсын эрэмбийг 1-2 байраар урагшлуулах боломжтой.

Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг олон улсын түвшинд авч үзвэл, дэлхийн дундаж оноо 2024 онд 2001 оноос хойших хамгийн доод түвшиндээ хүрсэн бөгөөд энэ нь дэлхийн улс орнуудад төсвийн тогтвортой байдал муудаж, төсвийн алдагдал нэмэгдэж, улс орнуудын өрийн хэмжээ ихсэж байгаатай холбоотой гэж дүгнэжээ. Эдийн засгийн эрх чөлөөт байдлаар Европын Холбооны улсууд болон Сингапур Улс тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна. Европын Холбооны улсуудад төрийн үйл ажиллагааны ил тод байдал өндөр хөгжсөн бол Сингапур Улсад өмчийн эрхийн хамгаалал, авлигын эсрэг хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж, ил тод өрсөлдөөнийг дэмжсэн зохицуулалт, бизнес эхлүүлэх үйл явц нь энгийн, хялбар байдаг байна. Харин эрэмбийн төгсгөлд Умард Солонгос, Куб, Венесуэл, Судан улсууд бичигджээ.

ШИГТГЭЭ 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

Монгол Улсад 2024 оны 2 дугаар улиралд болсон томоохон үйл явдлуудын нэг нь Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль байв. Сонгуулийн үр дүнгээр олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж хамтарсан Засгийн газрыг байгуулснаар 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдөр УИХ-аар батлуулаад байна. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр олон улсын зарим индексүүд дэх Монгол Улсын эрэмбийг урагшлуулах талаар хөтөлбөрийн үр дүнг¹⁴ тодорхойлсныг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Мэдээллийн эх сурвалж
			он	түвшин	
Хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байр ахиулна.	Хүний хөгжлийн индекс	байр	2022	96/193	НҮБХХ
Зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгална.	Зээлжих зэрэглэл	түвшин	2024	B3	Moody's
Эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс	байр	2024	76/176	The Heritage Foundation
Бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 3.5 оноонд хүргэн ахиулна.	Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ	оноо	2023	2.71	МҮХАҮТ
Дэлхийн инновацын үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	Дэлхийн инновацын индекс	байр	2023	68/132	World Intellectual Property Organization
Засаглалын үзүүлэлтийн дунджийг 10 байраар ахиулна.	Засаглалын үзүүлэлтийн дундаж	байр	2022	113/215	Дэлхийн банк
Дэлхийн сайн орны үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	Дэлхийн сайн орон индекс	байр	2022	106/169	Good Country Index
Авлигын үзүүлэлтийг 30 байраар ахиулна.	Авлигын төсөөллийн индекс	байр	2023	121/180	Transparency International
Ур чадварын индексийг 8 байраар ахиулна.	Олон улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт	түвшин	2023	64/64	IMD

Эдгээр үр дүнд хүрэхийн тулд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэр хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 600 орчим үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төлөвлөсөн үйл ажиллагааг үр дүнгийн үзүүлэлтүүдээр харвал, Хүний хөгжлийн үзүүлэлт, Дэлхийн инновацын үзүүлэлт, Ур чадварын индексийг сайжруулах хүрээнд хөтөлбөрийн “Хүний хөгжлийн бодлого” хоёрдугаар бүлэгт амьжиргааг дээшлүүлэх, эрүүл мэнд, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нөөц, дэд бүтцийг шинэчлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах, Бизнесийн орчны ерөнхий үнэлгээг ахиулах хүрээнд хөтөлбөрийн “Бусчилсан хөгжлийн бодлого” нэгдүгээр бүлэг, “Эдийн засгийн бодлого” гуравдугаар бүлэгт зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлэх үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэхээр тусгасан. Засаглалын үзүүлэлт болон Авлигын үзүүлэлтээр эрэмбэ ахиулах хүрээнд хөтөлбөрийн “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” дөрөвдүгээр бүлэгт төрийн үйлчилгээг цахимжуулах, төрийн үйлчилгээний үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлт, Дэлхийн сайн орны үзүүлэлт нь өргөн хүрээг хамардаг тул хөтөлбөрийн бүлэг бүрт туссан үйл ажиллагаанууд хамаарч, бизнесийн орчин, засаглалын чанар, хүний хөгжил, бүсчилсэн хөгжлийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

¹⁴ ЗГҮАХ-т тусгагдсан нийт үр дүнгээс зөвхөн олон улсын индексүүдийг авч оруулав.

Макро эдийн засгийн тойм
2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН
БАЙДЛААР

2024 он
8 сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Эдийн засгийн өсөлт: Эдийн засгийн өсөлт 2023 оны эцэст 7.4 хувь, 2024 оны эхний хагас жилд 5.6 хувь, 2024 оны эхний 7 сарын туршилт тооцоогоор 5.8 хувь байна. Өсөлтөд уул уурхай, тээвэр, барилга, боловсруулах, худалдаа, үйлчилгээний салбарууд эерэг хувь нэмэр оруулж байгаа бол хөдөө аж ахуйн салбар өсөлтийг хязгаарлалаа.

Экспорт: Экспорт 2024 оны эхний 8 сарын байдлаар 10.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өслөө. Өсөлтөд Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орсноор цэвэр зэс, алтны агуулга нэмэгдсэн, тээвэр зохион байгуулалт сайжирч төмрийн хүдэр, нүүрс тээвэр нэмэгдсэн, мөн дэлхийн зах зээл дэх алт, цэвэр зэсийн үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөллөө. Нүүрсний экспорт 9 дугаар сарын 12-ны өдөр 58 сая тоннд хүрсэн байна.

Төсөв: Монгол Улсын нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл 2024 оны 8 дугаар сарын байдлаар 3.4 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого 2024 оны 8 дугаар сард 19.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 их наяд төгрөг буюу 30.4 хувиар нэмэгдсэн байна. Дээрх өсөлтөд орлогын албан татвар 2.2 их наяд төгрөг буюу 57.3 хувиар, НӨАТ 823.7 тэрбум төгрөг буюу 28.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлснээр төсвийн зарлага 2024 оны 8 дугаар сард 17.3 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4.5 их наяд төгрөг буюу 35.4 хувиар нэмэгдсэн байна.

Инфляц: Инфляц 2024 оны 8 дугаар сард 6.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурлаа. Инфляцын бууралтад хүнсний бүтээгдэхүүн, хувцас, үйлчилгээний үнийн өсөлт саарсан нь голчлон нөлөөлөв. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8.1 сая толгой мал зүй бусаар хорогдсон нь махны нийлүүлэлт буурах, үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.

Өрх: Цалин нэмэгдсэнээр 2024 оны 2 дугаар улиралд өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 2.5 сая төгрөг болж, бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өслөө. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд харьцангуй тогтворжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар өссөн нь мөн өрхийн орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна. Өрхийн цалингийн орлогын өсөлт оны сүүлийн хагаст саарах ч инфляц нам түвшинд хадгалагдсанаар өрхийн бодит орлого өсөлттэй гарах төлөвтэй байна.

Хөдөлмөр: 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 68 мянган хүнээр нэмэгдэж 1,347 мянгад хүрлээ. Үүнд худалдааны салбарын ажилчид 47 мянгаар, үйлчилгээний салбарын ажилчид 41 мянгаар өссөн нь голчлон нөлөөлсөн байна. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар өсөж 62.2 хувьд хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс давсан үзүүлэлт юм.

Зээл: Зээлийн үлдэгдэл 2024 оны 7 дугаар сарын байдлаар 33.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 32.1 хувиар өссөн байна. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтөд цалин, тэтгэврийн зээл 9.7 нэгж хувийг, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 5.6 нэгж хувийг, бөөний болон жижиглэнгийн худалдаа 3.7 нэгж хувийг, боловсруулах үйлдвэрлэл 2.1 нэгж хувийг, уул уурхай, олборлолт 2.0 нэгж хувийг, өрхийн хэрэглээний болон хадгаламж барьцаалсан зээл 1.5 нэгж хувийг, хөдөө аж, ахуйн салбар 1.3 нэгж хувийг, санхүү даатгал 1.0 нэгж хувийг, барилгын салбар 0.7 нэгж хувийг, бусад салбарын зээл 4.5 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Зээлийн дундаж хүү 16.8 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар их байна.

Бодит сектор					
	нэгж	2023.I-II	2024.I-II	өөрчлөлт (%)	өөрчлөлт (₮)
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	30,980	37,420	20.8	6,440
Бодит ДНБ	тэрбум төгрөг	13,661	14,419	5.6	758
Өрхийн дундаж орлого (нэрлэсэн)	мянган төгрөг	2,024	2,509	24.0	486
		2023.II	2024.II	өөрчлөлт (%)	
Ажилчдын тоо	мянган хүн	1,279	1,347	5.3	
Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	59.6	62.2	2.6	
		2023.I-II	2024.I-II	өөрчлөлт (%)	
Бодит ДНБ-ий өсөлт (үйлдвэрлэл)	хувь	6.7	5.6	-1.1	
Уул уурхай	хувь	44.9	15.4	-29.5	
Уул уурхайн бус	хувь	3.0	4.2	1.2	
Хөдөө аж ахуй	хувь	-9.9	-26.7	-16.8	
Уул уурхай	хувь	44.9	15.4	-29.5	
Боловсруулах	хувь	1.6	6.3	4.8	
Цахилгаан	хувь	4.7	5.3	0.6	
Барилга	хувь	3.2	19.5	16.3	
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	хувь	7.4	6.8	-0.6	
Тээвэр	хувь	74.3	24.7	-49.6	
Мэдээлэл холбоо	хувь	11.9	17.4	5.5	
Бусад үйлчилгээний салбарууд	хувь	2.3	7.1	4.8	
Цэвэр татвар	хувь	2.4	15.0	12.6	
Бодит ДНБ-ий өсөлт (эцсийн ашиглалт)	хувь	6.3	5.7	-0.5	
Эцсийн хэрэглээ	хувь	8.7	23.5	14.8	
Хувийн	хувь	6.5	16.9	10.4	
Төрийн	хувь	17.0	46.9	29.9	
Хөрөнгийн нийт хуримтлал	хувь	-28.3	17.6	45.9	
Цэвэр экспорт	хувь	32.0	-81.9	-113.9	
		2023.08	2024.08	өөрчлөлт (нэгж %)	
Инфляц (хугацааны эцэст)	хувь	10.0	6.5	-3.5	
Хүнсний бараа, ундаа, ус	хувь	16.1	7.2	-8.9	
Хүнсний бус	хувь	7.6	6.2	-1.4	
Дотоодын	хувь	12.0	7.4	-4.6	
Импортын	хувь	7.6	5.4	-2.2	
Нэгдсэн төсөв					
		2023.08	2024.08	өөрчлөлт (%)	өөрчлөлт (₮)
Нийт орлого ба тусламж	тэрбум төгрөг	15,248	19,880	30.4	4,632
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	тэрбум төгрөг	14,609	18,890	29.3	4,281
Татварын орлого	тэрбум төгрөг	13,658	17,743	29.9	4,084
Орлогын албан татвар	тэрбум төгрөг	3,791	5,965	57.3	2,174
Нийгмийн даатгалын орлого	тэрбум төгрөг	2,391	2,865	19.8	474
Хөрөнгийн албан татвар	тэрбум төгрөг	227	270	19.0	43
Нэмэгдсэн өртгийн албан татвар	тэрбум төгрөг	2,931	3,755	28.1	824
Онцгой албан татвар	тэрбум төгрөг	527	724	37.2	196
Тусгай зориулалтын орлого	тэрбум төгрөг	15	17	13.0	2
Гадаад үйл ажиллагааны орлого	тэрбум төгрөг	935	1,144	22.4	209
Бусад татвар, төлбөр, хураамж	тэрбум төгрөг	2,841	3,003	5.7	162
Татварын бус орлого	тэрбум төгрөг	951	1,148	20.7	197
Нийт зарлага ба цэвэр зээл	тэрбум төгрөг	12,791	17,318	35.4	4,527
Урсгал зардал	тэрбум төгрөг	10,326	13,683	32.5	3,356
Хөрөнгийн зардал	тэрбум төгрөг	2,384	3,353	40.7	969
Цэвэр зээл	тэрбум төгрөг	81	283	248.6	202
Нийт тэнцэл	тэрбум төгрөг	2,458	2,562	4.3	105
Үндсэн тэнцэл	тэрбум төгрөг	3,277	3,460	5.6	183
Тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	1,818	1,572	-13.5	-246

Гадаад сектор					
	нэгж	2023.08	2024.08	өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)	
Экспорт	сая ам.доллар	10,004	10,625	6.2	621
Импорт	сая ам.доллар	5,947	7,502	26.1	1,555
Худалдааны тэнцэл	сая ам.доллар	4,057	3,123	-23.0	-934
Худалдааны эргэлт	сая ам.доллар	15,950	18,127	13.6	2,176
<i>Голлох бүтээгдэхүүний экспорт (үнийн дүн)</i>					
Чулуун нүүрс	сая ам.доллар	5,735	6,126	6.8	391
Хүрэн нүүрс	сая ам.доллар	89	70	-21.2	-19
Зэсийн баяжмал	сая ам.доллар	1,775	1,971	11.0	196
Алт	сая ам.доллар	426	585	37.5	160
Газрын тос	сая ам.доллар	237	223	-5.9	-14
Төмрийн хүдэр, баяжмал	сая ам.доллар	286	399	39.3	112
<i>Голлох бүтээгдэхүүний экспорт (биет хэмжээ)</i>					
Чулуун нүүрс	сая тонн	41	54	31.3	13
Хүрэн нүүрс	сая тонн	1.7	1.7	-2.3	0
Зэсийн баяжмал	мянган тонн	1,022	1,039	1.6	17
Алт	тонн	7	8	17.3	1
Газрын тос	мянган баррель	3,161	2,755	-12.8	-406
Төмрийн хүдэр, баяжмал	мянган тонн	3,660	4,848	32.5	1,188
<i>Үнэ</i>					
Чулуун нүүрс*	\$/тонн	140	114	-18.7	-26
Хүрэн нүүрс*	\$/тонн	51	41	-19.3	-10
Зэс	\$/тонн	8,620	9,118	5.8	498
Алт*	\$/унц	2,013	2,360	17.3	347
Газрын тос*	\$/баррель	75	81	8.0	6
Төмрийн хүдэр, баяжмал*	\$/тонн	78	82	5.1	4
*Хилийн үнэ					
<i>Импорт</i>					
Хэрэглээ	сая ам.доллар	2,061	2,612	26.7	551
Хүнс	сая ам.доллар	593	735	24.0	142
Бензин	сая ам.доллар	366	415	13.2	48
Суудлын авто машин	сая ам.доллар	452	684	51.3	232
Аж үйлдвэрлэлийн орц	сая ам.доллар	1,445	1,716	18.7	271
Химийн бүтээгдэхүүн	сая ам.доллар	127	172	36.0	46
Дизель түлш	сая ам.доллар	737	881	19.5	144
Цахилгаан эрчим хүч	сая ам.доллар	123	128	4.0	5
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	сая ам.доллар	2,431	3,166	30.2	734
Машин, механик тоног төхөөрөмж	сая ам.доллар	1,668	2,277	36.5	609
Барилгын материал	сая ам.доллар	753	878	16.6	125
Бусад	сая ам.доллар	8	10	26.8	2
		2023.08	2024.08	өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)	
Гадаад валютын нөөц	сая ам.доллар	3,933	4,704	19.6	771
Төгрөгийн ханш (оны эхнээс дундаж)	MNT/USD	3,476	3,385	-2.6	-91.5
		2023.07	2024.07	өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)	
Төлбөрийн тэнцэл	сая ам.доллар	452	-136		-589
Урсгал дансны тэнцэл	сая ам.доллар	334	-609		-943
Бараа, үйлчилгээний экспорт	сая ам.доллар	8,684	9,552		868
Бараа, үйлчилгээний импорт	сая ам.доллар	7,392	8,911		1,519
		2023.I-II	2024.I-II	өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)	
ШХО	сая ам.доллар	1,402	2,070	47.7	668
Уул уурхай	сая ам.доллар	1,048	1,701	62.3	653
Уул уурхайн бус	сая ам.доллар	354	369	4.2	15
Мөнгөний үзүүлэлтүүд					
		2023.07	2024.07	өөрчлөлт (%) өөрчлөлт (₮)	
Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт	хувь	18.5	30.4	11.9	
Зээлийн өсөлт	хувь	8.8	32.1	23.4	
Мөнгөний нийлүүлэлт	тэрбум төгрөг	32,021	41,754	30.4	9,734
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум төгрөг	25,144	33,224	32.1	8,080
Чанаргүй зээлийн үлдэгдэл	тэрбум төгрөг	2,218	1,959	-11.7	-259
Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	хувь	8.8	5.9		
Зээлийн жигнэсэн дундаж хүү	хувь	16.3	16.8		

ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ 10. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2
БОДИТ СЕКТОР						
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,453	43,555	53,852	70,442	16,663	37,420
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	-4.6	1.6	5.0	7.4	7.9	5.6
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	-4.4	1.6	5.0	7.2	8.0	5.7
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-12.6	17.6	11.4	5.4	32.5	27.7
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-2.7	-7.5	13.9	18.0	-7.2	-1.5
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	11.0	-8.5	-20.3	-16.2	-17.3	-20.5
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)						
Эцсийн хэрэглээ	3.6	-2.3	6.5	7.0	22.0	21.5
Өрхийн хэрэглээ	1.3	-4.0	5.1	6.3	12.7	12.1
Төрийн байгууллагын хэрэглээ	2.2	1.7	1.4	0.7	9.3	9.3
Хөрөнгийн нийт хуримтлал	-16.2	19.9	4.9	-1.6	10.5	6.2
Цэвэр экспорт	8.2	-16.0	-6.4	1.8	-24.5	-21.9
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0	5.1
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,178	9,315	8,815	8,479	8,443	9,094
Алтны үнэ* (\$/трой. унци)	1,772	1,799	1,802	1,943	2,074	2,206
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	43	71	99	82	82	83
ДНБ дефлятор (хувиар)	3.7	14.4	17.7	21.8	10.5	14.4
(тэрбум төгрөгөөр)						
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
Нийт орлого ба тусламжийн дүн	10,444	14,306	18,522	24,387	7,673	14,947
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,464	12,711	17,127	23,295	7,322	14,199
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904	15,630	18,160	22,509	5,695	12,911
Нийт тэнцэл	-3,460	-1,324	362	1,878	1,978	2,036
Нийт үндсэн тэнцэл	-2,521	-488	1,160	3,028	2,380	2,631
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,440	-2,919	-1,033	786	1,627	1,287
Тэнцвэржүүлсэн үндсэн тэнцэл	-3,501	-2,083	-235	1,936	2,028	1,883
ЗГ-ын нийт өр (ӨҮЦ)	62.3	50.8	52.4	38.6	33.7	33.2
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	27,899	26,918	31,965	30,778	29,772	30,247
МӨНГӨНИЙ СЕКТОР						
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	-12.7	6.5	39.9	7.4	11.7	29.6
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.5	1.6	1.8	1.9	2.0	1.9
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.4	5.8	4.4	5.2	6.1	5.5
Зээлийн өсөлт** (хувиар)	-4.0	18.5	7.5	22.7	22.3	27.3
(сая ам.доллароор)						
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ						
Төлбөрийн тэнцэл	787	-222	-727	1,457	373	-57
Урсгал дансны тэнцэл	-675	-2,108	-2,303	121	-251	-583
ГВАН	4,534	4,366	3,400	4,921	5,250	4,839
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	7.4	5.7	3.4	4.4	4.4	3.9
Гадаад валютын ханш						
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392	3,386
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376	3,381
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	43.0	41.3	38.8	37.6	39.4	39.6
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.9	102.8	105.7	111.1	117.6	118.9

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

ХҮСНЭГТ 11. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,453	43,555	53,852	70,442	16,663	37,420
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	26,655	27,092	28,455	30,567	6,077	14,419
(өсөлт, хувиар)						
Бодит ДНБ-ий өсөлт	-4.6	1.6	5.0	7.4	7.9	5.6
Уул уурхайн салбарын өсөлт	-9.9	0.8	-15.3	23.4	13.3	15.4
Уул уурхайн бус салбарын өсөлт	-3.7	1.8	8.2	5.4	7.0	4.2
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	-8.9	-24.8	-26.7
Уул уурхай	-9.9	0.8	-15.3	23.4	13.3	15.4
Боловсруулах аж үйлдвэр	3.4	-0.9	6.1	5.1	4.9	6.3
Цахилгаан дулаан	1.8	9.4	3.3	5.0	7.7	5.3
Барилга	-3.2	-22.8	8.2	3.1	27.7	19.5
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	5.8	10.1	6.8	6.0	6.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-18.2	-7.3	9.2	39.6	26.9	24.7
Мэдээлэл, холбоо	5.2	20.7	6.6	17.0	27.5	17.4
Бусад үйл ажиллагаа	-2.6	3.8	5.4	5.8	3.4	7.1
Цэвэр татвар	-9.4	12.2	11.5	6.6	13.1	15.0
Дефлятор	3.7	14.4	17.7	21.8	10.5	14.4
(нэгж хувиар)						
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо						
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-1.0	-3.9
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.9	1.8
Боловсруулах аж үйлдвэр	0.3	-0.1	0.5	0.4	0.3	0.4
Цахилгаан дулаан	0.0	0.2	0.1	0.1	0.3	0.2
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.2	0.3
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.0	-0.3	0.4	1.8	1.3	1.0
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.2	0.5	0.9	0.6
Бусад үйл ажиллагаа	-0.7	1.1	1.6	1.7	1.2	2.1
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1	2.3
(тэрбум төгрөгөөр)						
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,883	44,703	54,878	71,202	17,473	38,022
Анхдагч орлого	-3,526	-6,359	-5,072	-7,738	-1,693	-4,465
Үндэсний нийт орлого	34,357	38,344	49,806	63,463	15,780	33,558
Хоёрдогч орлого	769	1,223	1,363	1,378	592	857
Үндэсний нийт цэвэр орлого	35,126	39,566	51,169	64,841	16,372	34,414
Нийт дотоод эрэлт	36,953	45,574	58,219	64,404	17,098	36,042
Үндэсний хадгаламж	6,556	9,985	15,746	24,317	4,001	8,357
Хөрөнгийн нийт хуримтлал	8,383	15,993	22,796	23,880	4,727	9,985

ХҮСНЭГТ 12. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2
	(тэрбум төгрөгөөр)					
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444	14,306	18,522	24,387	7,673	14,947
Ирээдүйн өв сан	914	967	0	416	284	528
Тогтворжуулалтын сан	66	628	1,395	676	67	221
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,464	12,711	17,127	23,295	7,322	14,199
Татварын орлого	8,512	11,300	15,459	21,484	6,909	13,291
Орлогын албан татвар	2,227	3,326	3,827	5,703	2,557	4,266
Нийгмийн даатгалын орлого	1,586	2,286	3,038	3,951	920	2,105
Хөрөнгийн албан татвар	155	201	238	395	109	240
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,209	2,838	3,946	4,777	1,286	2,777
Онцгой албан татвар	777	827	848	790	280	515
Тусгай зориулалтын орлого	17	17	19	22	6	13
Гаалийн албан татвар	741	939	1,256	1,465	352	813
Бусад татвар, төлбөр, хураамж	800	866	2,288	4,382	1,398	2,561
Татварын бус орлого	952	1,412	1,668	1,811	413	908
Нийтлэг татварын бус орлого	785	1,250	1,364	1,452	339	717
Хөрөнгийн орлого	1	2	4	8	1	2
Тусламжийн орлого	166	160	300	351	73	188
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904	15,630	18,160	22,509	5,695	12,911
Урсгал зарлага	10,829	12,804	14,229	17,091	4,698	10,376
Цалин, хөлс	2,649	2,532	1,666	2,327	1,081	2,585
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,202	2,170	2,140	2,758	687	1,660
Татаас	375	454	537	580	134	367
Урсгал шилжүүлэг	4,663	6,813	9,088	10,276	2,394	5,170
Зээлийн үйлчилгээний төлбөр	939	836	798	1,150	402	595
Гадаад	776	681	694	1,054	395	582
Дотоод	163	155	104	96	6	13
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,075	2,826	3,930	5,418	997	2,535
Хөрөнгийн зардал	3,034	2,982	3,803	5,188	843	2,296
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41	-156	127	229	154	239
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,460	-1,324	362	1,878	1,978	2,036
НИЙТ ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-2,521	-488	1,160	3,028	2,380	2,631
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-4,440	-2,919	-1,033	786	1,627	1,287

ХҮСНЭГТ 13. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023
	(ДНБ-д эзлэх хувиар)			
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27.9	32.8	34.4	34.6
Ирээдүйн өв сан	2.4	2.2	0.0	0.6
Тогтворжуулалтын сан	0.2	1.4	2.6	1.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	25.3	29.2	31.8	33.1
Татварын орлого	22.7	25.9	28.7	30.5
Орлогын албан татвар	5.9	7.6	7.1	8.1
Нийгмийн даатгалын орлого	4.2	5.2	5.6	5.6
Хөрөнгийн албан татвар	0.4	0.5	0.4	0.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	5.9	6.5	7.3	6.8
Онцгой албан татвар	2.1	1.9	1.6	1.1
Тусгай зориулалтын орлого	0.0	0.0	0.0	0.0
Гаалийн албан татвар	2.0	2.2	2.3	2.1
Бусад татвар, төлбөр, хураамж	2.1	2.0	4.2	6.2
Татварын бус орлого	2.5	3.2	3.1	2.6
Нийтлэг татварын бус орлого	2.1	2.9	2.5	2.1
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	0.4	0.4	0.6	0.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37.1	35.9	33.7	32.0
Урсгал зарлага	28.9	29.4	26.4	24.3
Цалин, хөлс	7.1	5.8	3.1	3.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	5.9	5.0	4.0	3.9
Татаас	1.0	1.0	1.0	0.8
Урсгал шилжүүлэг	12.5	15.6	16.9	14.6
Зээлийн үйлчилгээний төлбөр	2.5	1.9	1.5	1.6
Гадаад	2.1	1.6	1.3	1.5
Дотоод	0.4	0.4	0.2	0.1
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	8.2	6.5	7.3	7.7
Хөрөнгийн зардал	8.1	6.8	7.1	7.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0.1	-0.4	0.2	0.3
НИЙТ ТЭНЦЭЛ	-9.2	-3.0	0.7	2.7
НИЙТ ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-6.7	-1.1	2.2	4.3
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-11.9	-6.7	-1.9	1.1

ХҮСНЭГТ 14. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2
	(сая ам.доллараар)					
I. УРСГАЛ ДАНС	-675	-2,108	-2,303	121	-251	-583
Бараа	1,756	1,370	1,233	4,549	920	1,865
Экспорт Ф.О.Б (кредит)	6,991	8,136	9,854	13,914	3,431	7,443
Импорт Ф.О.Б (дебит)	5,235	6,766	8,622	9,366	2,511	5,578
Үйлчилгээ	-1,450	-1,675	-2,355	-2,592	-846	-1,383
Кредит	655	814	1,135	1,587	275	615
Дебит	2,105	2,490	3,490	4,179	1,121	1,998
Анхдагч орлого	-1,253	-2,232	-1,615	-2,233	-499	-1,319
Кредит	341	292	344	455	132	279
Дебит	1,595	2,524	1,959	2,687	631	1,598
Хоёрдогч орлого	273	429	434	398	175	253
II. ХӨРӨНГИЙН ДАНС	103	114	154	135	32	78
Кредит	105	116	166	149	36	87
Дебит	2	2	12	14	4	9
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-1,504	-1,982	-1,644	-1,477	-857	-660
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-1,693	-2,060	-2,428	-2,172	-580	-1,464
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	563	25	445	818	-16	-252
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	-6	-8	-11	-2	8	0
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-369	60	351	-121	-269	1,056
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	278	245	298	354	-245	894
Зээл	-803	-501	67	-529	-86	-43
Худалдааны зээл	156	413	-15	54	61	205
IV. Алдаа болон орхигдуулга	-146	-209	-222	-276	-265	-213
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	787	-222	-727	1,457	373	-57
V. Нөөц хөрөнгө	787	-222	-727	1,457	373	-57
ГВУН	787	-225	-751	1,398	359	-96
ОУВС-гийн зээл	0	-3	-24	-59	-14	-38
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325	4,912	11,052
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921	5,250	4,839
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4	4.4	3.9
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392	3,386
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376	3,381

ХҮСНЭГТ 15. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023
	(ДНБ-д эзлэх хувиар)			
I. УРСГАЛ ДАНС	-5.1	-13.8	-13.4	0.6
Бараа	13.2	9.0	7.2	22.4
Экспорт Ф.О.Б (кредит)	52.5	53.2	57.5	68.5
Импорт Ф.О.Б (дебит)	39.3	44.3	50.3	46.1
Үйлчилгээ	-10.9	-11.0	-13.7	-12.8
Кредит	4.9	5.3	6.6	7.8
Дебит	15.8	16.3	20.4	20.6
Анхдагч орлого	-9.4	-14.6	-9.4	-11.0
Кредит	2.6	1.9	2.0	2.2
Дебит	12.0	16.5	11.4	13.2
Хоёрдогч орлого	2.1	2.8	2.5	2.0
II. ХӨРӨНГИЙН ДАНС	0.8	0.7	0.9	0.7
Кредит	0.8	0.8	1.0	0.7
Дебит	0.0	0.0	0.1	0.1
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-11.3	-13.0	-9.6	-7.3
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-12.7	-13.5	-14.2	-10.7
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	4.2	0.2	2.6	4.0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	0.0	0.0	-0.1	0.0
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-2.8	0.4	2.0	-0.6
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	2.1	1.6	1.7	1.7
Зээл	-6.0	-3.3	0.4	-2.6
Худалдааны зээл	1.2	2.7	-0.1	0.3
IV. Алдаа болон орхигдуулга	-1.1	-1.4	-1.3	-1.4
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	5.9	-1.4	-4.2	7.2
V. Нөөц хөрөнгө	5.9	-1.4	-4.2	7.2
ГВУН	5.9	-1.5	-4.4	6.9
ОУВС-гийн зээл	0.0	0.0	-0.1	-0.3
Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0
Нэмэлт үзүүлэлтүүд:				
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411

ХҮСНЭГТ 16. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2
	(тэрбум төгрөгөөр)					
Гадаад цэвэр актив	5,816	3,806	2,492	8,959	9,775	9,865
Дотоод цэвэр актив	18,664	24,057	27,173	28,665	27,625	31,603
Дотоодын цэвэр эзэл	19,136	24,298	25,648	29,106	28,477	32,296
Бусад цэвэр зүйлс	-472	-241	1,525	-441	-852	-694
М2 мөнгө	24,481	27,863	29,665	37,624	37,400	41,467
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	753	847	831	906	827	1,040
Харилцах болон хадгаламж	23,728	27,016	28,834	36,719	36,573	40,428
	(өсөлт, хувиар)					
Жилийн өсөлт						
М2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9
Гадаад цэвэр актив	80.9	-34.6	-34.5	259.6	148.4	146.7
Дотоод цэвэр активын өсөлт	4.6	28.9	13.0	5.5	2.3	15.1
Дотоодын цэвэр эзэл	2.3	27.0	5.6	13.5	12.4	20.2
ЗГ-аас авах авлага	-29.6	-49.8	107.6	91.3	57.9	53.9
Бусад салбараас авах авлага	-2.2	19.2	9.9	19.8	18.5	24.8
Улсын байгууллагаас авах авлага	1,492.6	25.0	-5.0	-16.7	-8.6	13.2
Хувийн сектороос авах авлага	-7.2	18.8	10.8	21.7	19.8	25.2
	(нэгж хувиар)					
М2 мөнгөний өсөлт дэх оролцоо						
М2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9
Гадаад цэвэр актив	12.4	-8.2	-4.7	21.8	18.9	18.7
Дотоод цэвэр актив	3.9	22.0	11.2	5.0	2.0	13.2
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Мөнгөний эргэлтийн хурд	1.5	1.6	1.8	1.9	2.0	1.9
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	-1.0	16.3	23.6	30.8	19.3	20.8
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0	5.1

ХОЛБОО БАРИХ:

Утас: +976-51-263333

Факс: +976-51-263333

И-мэйл: MEPD@med.gov.mn

Вэбсайт: med.gov.mn

Фэйсбүүк: [medgovMN](https://www.facebook.com/medgovMN)

ХАЯГ:

Эдийн засаг, хөгжлийн яам

Монгол Улс, Улаанбаатар хот,

Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж

Засгийн газрын XI байр